

ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ХОТЫН ИНДЕКС ТОГТООХ СУДАЛГАА

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Улаанбаатар хот, 2022

АГУУЛГА

Нэг. Үндсэн ойлголт, нэр томъёоны тайлбар	2-27
Хоёр. Бодлого, эрх зүйн орчин, үйл ажиллагааны өнөөгийн байдал.....	28-43
Гурав. Хүүхдэд ээлтэй хотын олон улсын туршлага	44-55
Дөрөв. Хүүхдэд ээлтэй хотын индекс, шалгуур үзүүлэлт, арга аргачлал.....	56-64
Тав. Чанарын судалгааны удирдамж	65-70
Ном зүй.....	71-73
Хавсралт (<i>Параметрийн үзүүлэлтүүдийн тодорхойлолт</i>).....	74-100

Зураг, хүснэгтийн жагсаалт

Зураг 1. Хүүхдийн үндсэн эрхүүд

Зураг 2. Хүн амд эзлэх хүүхдийн тоо, хувь

Зураг 3. Хүүхдийн эмчийн тоо сонгогдсон онуудаар

Зураг 4. Хүүхдүүдийн чөлөөт цагаараа хийх дуртай зүйлс

Зураг 5. Хүүхдүүд чөлөөт цагаа зөв өнгөрүүлэхэд хэрэгцээтэй зүйлс

Зураг 6. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн шийтгүүлсэн шалтгаан (хувиар)

Зураг 7. Хүүхдэд ээлтэй хот: Өөрчлөлтийн онол

Зураг 8. Шалгуур үзүүлэлтийн индексийн үр дүн

Зураг 9. Хүүхдэд ээлтэй хот Минск

Зураг 10. Хүүхдэд ээлтэй хотын 8-12 настай хүүхдээс авах судалгааны асуулгын загвар

Хүснэгт 1. Нийслэлийн хэмжээнд 3 ээлжээр хичээллэж буй сургуулиуд оноор, тоогоор

Хүснэгт 2. Сургуулийн орчны аюулгүй байдал (Асуулга, n=500)

Хүснэгт 3. Нэг сурагчид ногдох анги танхимын талбай (Захирлын асуулга)

ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ХОТЫН ИНДЕКС ТОГТООХ СУДАЛГАА

Нэг. Үндсэн ойлголт, нэр томъёоны тайлбар

- 1.1. Хүүхдийн нийгмийн оролцоо
- 1.2. Хүүхдийн амьдрах орчин
- 1.3. Хүүхдийн аюулгүй байдал
- 1.4. Хүүхдийн эрүүл мэнд, эрүүл амьдралын хэв маяг
- 1.5. Хүүхдийн боловсрол ба хөгжил
- 1.6. Хүүхдийн чөлөөт цаг соёл хүмүүжлийн ажил
- 1.7. Хүүхдэд нэн шаардлагатай үйлчилгээний хүртээмж

1.1. ХҮҮХДИЙН НИЙГМИЙН ОРОЛЦОО

Хүний эрхийн үндсэн баримт бичгүүд, хүүхдийн эрхийн конвенцид зааснаар улс орнууд нь нийгмийн болон боловсролын тогтолцоо, хүүхдийн асуудлаар шийдвэр гаргах бүх үе шатанд хүүхдийн оролцоог хангах механизмыг бий болгох шаардлагатайг заасан байдаг. Хүүхдэд ээлтэй хотыг бий болгоход бодлого шийдвэр, үйл ажиллагаанд хүүхдийн өөрсдийнх нь оролцоо байна уу? Хүүхдийн төлөө ажилладаг бие даасан байгууллага байна уу? Нийгмийг хөгжүүлэх, бодлого боловсруулахад хүүхдийг оролцуулж байна уу? Ардчилсан, хүнлэг, энэрэнгүй нийгмийн орчинг бий болгоход хүүхдийн оролцоо байна уу? зэрэг асуудал чухлаар тавигдаж байна. Гэтэл өнөөдрийн байдлаар хүүхдийн нийгмийн оролцоог хүндэтгэн үзэж аливаа бодлого, шийдвэр гаргахдаа энэ талаар тусгах үйл ажиллагаандаа мөрдлөг болгож чадахгүй байсаар байна. Иймд хүүхдэд чиглэсэн үйл ажиллагаа, хүүхдийн өөрсдийн оролцоог бий болгох, оролцоог хангах арга замуудыг нэвтрүүлэх, түгээн дэлгэрүүлэх шаардлага гарч байна. **“Хүүхдийн эрхийн конвенцид”** хүүхдийн оролцооны эрхийг дараах байдлаар тусгасан байдаг. Үүнд:

- *Тавдугаар зүйл: Төр засаг нь эцэг эхчүүдийн болон гэр бүлийн хүүхдээ удирдан хөтлөх эрх, үүрэг, хариуцлагыг хүндэтгэнэ.*
- *Арван хоёрдугаар зүйл: Хүүхдүүд өөртэй нь холбоотой бүх асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, идэвхитэй оролцох эрхтэй бөгөөд хүүхдийн үзэл бодолд зохих анхаарал тавих эрхтэй.*

- Арван гуравдугаар зүйл: Хүүхэд бүр санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй.
- Арван дөрөвдүгээр зүйл: Хүүхэд бүр чөлөөтэй бодож сэтгэх, сүсгэлэх, шашин шүтлэгтэй байх эрхтэй.
- Арван тавдугаар зүйл: Хүүхэд бүр эвсэл холбоо байгуулах, тайван замаар жагсаал, цуглаан хийх эрхтэй.
- Гучиннэгдүгээр зүйл: “Оролцогч улсууд хүүхдийн амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх, насныхаа онцлогт тохирсон тоглоом болон наадамд оролцох, соёлын амьдрал, урлан бүтээх үйл ажиллагаанд чөлөөтэй оролцох эрхийг хүлээн зөвшөөрнө.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог зайлшгүй хангах, энэ тал дээр улс орон төр засаг хийгээд эцэг эх асран хамгаалагч туслалцаа үзүүлэх шаардлагатай.

Хүүхэд гэж хэн бэ?

18 нас хүрээгүй хүн бүрийг “Хүүхэд” гэж ХЭК-ийн нэгдүгээр зүйлд заасан бөгөөд хүүхдийн үндсэн эрхийг хэн, хэрхэн хамгаалах тухай маш тодорхой тусгасан байдаг. (ХЭК-ийн 1-р зүйл). Хүний эрхийн нэг хэсэг том салаа мөчир бол хүүхдийн эрх юм. Хүүхдийн үндсэн эрхэд амьдрах эрх, хамгаалуулах эрх, хөгжих эрх, нийгэм, соёлын амьдралд оролцох эрхүүд багтдаг. Хүүхдийн эрхийн тухай конвенц болон Хүүхдийн эрхийг хамгаалах тухай монгол улсын хуульд хүүхдийн эдлэх эрхийг:

ХӨГЖИХ ЭРХ

ОРОЛЦОХ ЭРХ



АМЬДРАХ ЭРХ

ХАМГААЛУУЛАХ
ЭРХ

Зураг 1. Хүүхдийн үндсэн эрхүүд

гэсэн дөрвөн үндсэн бүлэг агуулгаар авч үзсэн байна. Тухайлбал,

- Амьдрах эрхтэй: Амьдрах, эрүүл мэнд, хүнсний хангамж, нэр, иргэний харъяалал
- Хамгаалуулах эрхтэй: Дарамт, хүчирхийлэл, мөлжлөг
- Хөгжих эрхтэй: Боловсрол, хамгаалал, чөлөөт цаг, урлаг, соёлын арга хэмжээнүүд

🌈 Оролцох эрхтэй: Санал бодол, мэдээлэл, шашин, үзэл бодол

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд гэж хэн бэ?

Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэгт бие махбод, оюун санаа сэтгэл мэдрэл мэдэрхүйн байнгын согогтой бөгөөд уг согог нь бусад төрлийн бэрхшээлтэй нэгдэн нийлсний улмаас бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн үр дүнтэй оролцоход нь саад учруулахуйц болсон байдлыг хэлнэ¹. НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенц 7-р зүйлд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцооны талаар заасан байдаг. Тухайлбал,

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд бусад хүүхдийн нэгэн адил хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлүүлэх явдлыг хангахад бүхий л шаардлагатай арга хэмжээг авна.
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэхдээ хүүхдийн ашиг сонирхолыг нэн түрүүнд харгалзан үзнэ.
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд бусад хүүхдүүдийн нэгэн адил өөрсдийн нас болон биеийн онцлогт тохирсон байдлаар өөрт нь хамаарах аливаа асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй эдлэх эрхийг эдлүүлэх бөгөөд энэхүү эрхээ эдлэхэд нь хөгжлийн бэрхшээл болон насны онцлогт тохирсон туслалцаа үзүүлэх явдлыг хангана.

Мөн НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 12-р зүйлийн зарим зүйлийг тайлбарлавал:

“Өөрийн үзэл бодолтой байх чадвартай” – гэдэг нь бүх хүүхдийг өөрийн үзэл бодлоо ямар нэг хэлбэрээр илэрхийлэхийг дэмжих ёстойг хэлж буй бөгөөд түүний оролцоонд насны доод хязгаар гэж байхгүйг илэрхийлдэг. Бүр бага насны хүүхдүүд ч хүртэл өөрийгөө илэрхийлэх аргуудтай байдаг. Энэ зарчим нь бүх хүүхдүүдэд хамаарах бөгөөд үүнд охид, хөвгүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, өөр соёл, өөр газраас гаралтай хүүхдүүд бүгд багтана.

“Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх” – гэдэг нь хүүхдэд өөрийн үзэл бодлоо боловсруулах, илэрхийлэхэд цаг хугацаа, урам, дэмжлэг хэрэгтэй. Энэ нь хэрэв хүүхэд хүсэхгүй бол оролцохгүй байж болно гэсэн үг. Хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх нь эрх болохоос үүрэг биш.

“Хүүхэдтэй холбоотой бүхий л асуудлаар” – Хүүхдэд хамааралтай шийдвэрийг олон өөр газар, янз бүрийн түвшинд гаргадаг. Шийдвэр өдөр бүр гэр бүл, сургууль, ажлын байранд, олон нийтийн дунд, шүүх болон захиргаа, үндэсний

¹ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц 7-р зүйл, 12-р зүйл

болон олон улсын түвшинд гарч байдаг². (Хүүхдийн оролцоог дэмжих арга зүй” УБ., 2020 он)

1992 онд судлаач Рожер Харт нь оролцоо хэмээх ойлголтын анхны өргөн хүрээтэй тодорхойлолтыг гаргасан. Тэрээр оролцоог хүүхдийн төсөлд хамрагдах түвшин бүхий шаттай зүйрлээд, оролцоогүйгээс бүрэн оролцоо хүртэлх бүх шатлалыг дүрслэн үзүүлжээ. Оролцооны найман түвшинг тогтоогоод, үүнийгээ “Оролцооны шат” хэмээн нэрлэжээ.

Монгол Улс Хүүхдийн Эрхийг хамгаалах тухай хуулиараа оролцох эрхийн хамгаалалтыг дараах байдлаар баталгаажуулсан.

Хүүхдийн эсэн мэнд амьдрах эрхийн хүрээнд: Хүүхэд төрмөгцөө нэр авах, улсын харьяат байх эрхтэй бөгөөд хүүхэд гадаадын харьяат болох, гадаадын иргэн, харьяалалгүй хүний хүүхэд тухайн улсын харьяат болох асуудлыг хууль ба олон улсын гэрээгээр зохицуулна. Хүүхэд эрүүл өсөж бойжих, аюулгүй орчинд амьдрах, аливаа хүчирхийллээс ангид байх эрхтэй. Хүүхэд эцэг эхтэйгээ амьдрах, тэдний анхаарал халамжид байх, эцэг эхээсээ буюу хэн нэгнээс нь тусдаа амьдрах үед тэдэнтэй байнгын харилцаатай байх, эцэг, эх нь гэрлэлтээ цуцлуулсан, тусдаа амьдрах үед хэнтэй нь амьдрах тухай үзэл бодол саналаа илэрхийлэх эрхтэй.

Хүүхдийн нийгмийн амьдралд оролцох эрх: Хүүхэд нас бие сэтгэхүйн онцлогт тохирсон хуулиар хориглоогүй арга хэмжээнд оролцох, эвлэлдэн нэгдэх; өөрт хамаарах аливаа асуудлаар шийдвэр гаргах, үнэлэлт өгөхөд оролцох; өөрийн бүтээсэн зохиогчийн эрх, шинэ бүтээл, оновчтой саналыг хууль тогтоомжид заасны дагуу өмчлөх, түүний үр шимийг хүртэх; хүүхэд хуульд заасан үндэслэл журмын дагуу өөрт ногдох эд хөрөнгийг өмчлөх, өвлөх, ажил, үйлчилгээний хөлс, урамшуулал авах; хуулиар олгогдсон эрхээ эдлэх, шаардах эрхтэй гэж тус тус заасан байдаг.

Монгол улсын үндсэн хүүхдийн эрхийн тухай хуулийн 8-р зүйлд зааснаар: 8 дугаар зүйл. Хүүхдийн нийгмийн амьдралд оролцох эрх:

8.1. Хүүхэд нийгмийн амьдралд оролцох эрхтэй бөгөөд хүүхэд нийгмийн амьдралд оролцохдоо дараахь эрх эдэлнэ:

8.1.1. хүүхэд нас, бие, сэтгэхүйн онцлогт тохирсон хуулиар хориглоогүй арга хэмжээнд оролцох, эвлэлдэн нэгдэх;

8.1.2. хүүхэд өөрт хамаарах аливаа асуудлаар шийдвэр гаргах, үнэлэлт өгөхөд оролцох;

8.1.3. хүүхэд өөрийн бүтээсэн зохиогчийн эрх, шинэ бүтээл, оновчтой саналыг хууль тогтоомжид заасны дагуу өмчлөх, түүний үр шимийг хүртэх;

8.1.4. хүүхэд хуульд заасан үндэслэл журмын дагуу өөрт ногдох эд хөрөнгийг өмчлөх, өвлөх, ажил, үйлчилгээний хөлс, урамшуулал авах гэсэн оролцоог хангах тухай тус тус заажээ.

1.2. ХҮҮХДИЙН АМЬДРАХ ОРЧИН

Сүүлийн жилүүдэд хүүхдүүдийн сурч боловсрох амьдрах орчин нөхцөл хангалттай зохицуулалтгүй байгаагийн улмаас хүүхдийн эрх маш ихээр зөрчигдөх болсон. Тиймээс бид хүүхдийн эрх ба амьдрах орчин хоёр хэрхэн холбоотой болох, талаарх мэдээллийг судлах юм. Хүүхдийн амьдрах орчин нь хүүхэд бүр сурч хөгжихөд таатай, аюулгүй, хүүхдэд ээлтэй, хүчирхийлэлгүй орчин байх ёстой. Хүүхдийн амьдрах таатай орчинг бүрдүүлэх, эрүүл аюулгүй орчинд сурж боловсрох эрхийг нь хамгаалахад оршино.

Хүүхдийн амьдрах орчин ямар байх шаардлагатай вэ?

Хүүхэд нас гэдэг хүн бүрийн хувьд хамгийн үнэ цэнэтэй, амьдралын бүхий л эхлэл, суурь хүмүүжил тавигддаг үе. Монгол улсын хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулинд "Хүүхэд эрүүл мэнд өсөж бойжих, аюулгүй орчинд амьдрах эрхтэй" гэж заасан байдаг төдийгүй орон байр, ахуйн хэрэгслээр гачигдуулахгүй байх тухай заалт байдаг.

Монгол судлаачид хүүхдийн эрхийн зөрчил болон сургуулийн орчны талаар нэлээдгүй судалсан байдаг хэдий ч хүүхдийн амьдрах орчин, ахуйн нөхцөл ямар байгаа тухай судалгаа хомс байна.

Хүүхдийн амьдарч буй орчин нь (Living condition) тэдний эрүүл мэнд, сэтгэл зүй болоод ирээдүйд ямар хүн болж төлөвшихөд том нөлөө үзүүлдэг. Тиймээс гэр бүл бүр орон сууц, орчин нөхцөлийн стандартыг баримтлан хүүхдээ эрүүл аюулгүй, тохилог ногоон байгууламж, цэвэр цэнгэг агаар бүхий газар өсгөж торниулах нь бидний үүрэг болж байна.

Английн судлаач Lisa Harker болон Shelter нарын хамтран гаргасан "Chance of a lifetime" (COAL) судалгаагаар орчны нөхцөл тааруухан газар амьдарч буй хүүхдийн ирээдүйн эрүүл мэнд муу байх болон хойшид хөдөлмөрийн чадвараа алдах магадлал 25%-иар их байх нь тогтоогдсон байна. Түүнчлэн хүүхэд стандартын шаардлага хангаагүй орчинд өсөн торнисноор менингит, астма, зүрхний өвчлөлтэй болох магадлал ихэсдэг төдийгүй сурах чадвар, зан төлөв, ирээдүйд ажил эрхлэх чадвар зэрэгт ч сөргөөр нөлөөлдөг байна. Иймд зарим орнуудад хүүхэд төрснөөс эхлэн тэдэнд зориулан тохь тухтай тусгай өрөөг бэлдэхийг шаарддаг. Тухайлбал, Австрали улсад гэр бүл хүүхэд бүрийн тоогоор тус тусдаа өрөөтэй байх хэрэгтэй бөгөөд энэ нь байр хөлслөхөд ч мөн хамаатай байдаг байна. Өөрөөр хэлбэл 2-3 хүүхэдтэй айл заавал 3-4 өрөө байр хөлслөх эсвэл худалдаж авахыг амьдралын зарчим болгосон байдаг.

Хүүхдийн амьдрах орчинд дараах шаардлагууд хангагдсан байх ёстой.
Үүнд:

- ✓ Эрүүл амьдрах орчин: Хүүхдэд хамгийн түрүүнд цэвэр агаар, тохилог орчин хэрэгтэй.

500 жилийн өмнө Их Британичууд үйлдвэрлэлд төдийгүй гэр халаах зорилгоор нүүрсийг ихээр хэрэглэдэг байсан. Мөн 200 жилийн өмнө Их Британид Аж үйлдвэрийн хувьсгал хийгдэж байх үеэр агаарын бохирдол, утаа тэдний хувьд хамгийн том асуудал болж байлаа. Энэ үеэр 18'000'000 хүүхдүүд амьсгалын замын өвчнөөр өвдөж байсан харамсалтай тоо баримт байдаг байна.

Бидний хувьд ч мөн адил утаа том асуудал болж байгаа энэ цагт хүүхдүүд болон гэр бүлээ цэвэр агаартай орчинд амьдруулах нь маш чухал болж байна. Ялангуяа хүүхэд ихэнх цагийг гэртээ өнгөрөөж буй бол гэрийн агаарын бохирдлыг шалгах, хэмжих цэвэршүүлэх, боломжтой бол цэвэр агаартай газар сэлгэн нүүх зэрэг арга хэмжээг авч байх нь зүйтэй.

- ✓ *Сурч боловсроход таатай орчин:*

Хүүхэд гэртээ төдийгүй сургууль дээрээ сурч боловсроход шаардлагатай эд зүйлс, орчин нөхцөлөөр хангагдсан байх ёстой. Тэднийг хичээлийн болон хичээлийн бус сургалт клубд суралцуулах замаар өөрийгөө хөгжүүлэхэд нь дэмжиж, нийгмийн амьдралд оролцоход туслах нь эцэг эхчүүдийн үүрэг хариуцлагын нэг.

- ✓ *Эдийн засгийн хувьд хүрэлцээт орчин:*

Хүүхэд багаасаа эдийн засаг санхүүгийн хувьд тааламжит орчин нөхцөлд өсөн хүмүүжих бүхий л хэрэгцээ шаардлагаар хангагдах ёстой төдийгүй тэднийг ирээдүйн ажил эрхлэлтээ олох хүртэл шаардлагатай хоол хүнс, эд зүйлсээр хангаж байх нь эцэг эхчүүдийн бас нэгэн үүрэг билээ.

Хүүхэд нь амьдарч буй орчиндоо хуулийг даган мөрдөж, хуулийн дагуу эрх, үүргээ эдлэх ёстой. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд хүүхдийн эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэх харилцааг зохицуулж буй зүйл заалтууд байдгаас амьдрах орчинд хэрэгжиж буй зүйл заалтуудыг тусган авч үзвэл:

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт:

- 1.1. Энэ хуулийн зорилт нь хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн бүрэн эрхийг тодорхойлж, хүүхдийн эрхийг хангах тогтолцоог бий болгох, хүүхдийн эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хүүхэд нь 18 нас хүртэл хуулийн дагуу хүүхдийн эрх эдэлнэ. Үүнийг 3.1. хуулийн заалтад тусгаж өгсөн байдаг.

3 дугаар зүйл. Хүүхдийн үйлчлэх эрх

3.1. Хүүхдийг төрсөн цагаас нь эхлэн 18 насанд хүртэлх эрхийг нь хангахад энэ хууль үйлчилнэ.

3.2. Энэ хууль Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүний хүүхдэд нэгэн адил хамаарна.

Хуульд зааснаар хүүхэд амьдрах явцдаа дараах зарчмуудын хүрээнд эрх, үүрэг эдэлнэ. 4 дүгээр зүйл

Хүүхдийн эрхийн үндсэн зарчим

4.1. Хүүхдийн эрхийг хамгаалахад дараахь зарчмыг баримтална:

4.1.1. хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй байх;

4.1.2. төр, иргэн, хуулийн этгээд үйл ажиллагаа явуулахдаа хүүхдийн язгуур эрхийг эн тэргүүнд хангахыг эрхэмлэж, хүүхэд эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг тэгш хангах;

4.1.3. хүүхдийн нас, төлөвшлийн байдлыг харгалзан, түүний үзэл бодолд хүндэтгэлтэй хандах;

4.1.4. хүүхдийн эрхийг хангахад үндэсний уламжлалт зан заншил, ёс суртахууны үнэт зүйлд тулгуурлах;

4.1.5. хүүхдийг нас, бие, сэтгэхүйн онцлогт нь тохирсон мэдээ, мэдээллээр хангах

Хүүхэд амьдрах явцдаа дараах эрхээр хамгаалуулж, хуулийн дагуу зохицуулалт хүсэх эрх бүрддэг.

7 дугаар зүйл. Хүүхдийн хамгаалуулах эрх

7.1. Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодийн шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй.

7.2. Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүүхдийн эрхийг нь зөрчсөн тохиолдолд хүүхэд тэдэнтэй хууль ёсны харилцаагаа зохих журмын дагуу зогсоох, таслах, тухайн нөхцөл байдал арилсан тохиолдолд уг харилцаагаа сэргээх эрхтэй.

7.3. Хүүхэд өөрийн нэр төр, гэр бүлийн амьдрал, хувийн мэдээлэл, орон байрны халдашгүй байдал, хувийн орон зайгаа хамгаалуулах эрхтэй.

7.4. Хүүхэд эрхээ зөрчигдсөн тохиолдолд өөрөө болон итгэмжит төлөөлөгчөөрөө дамжуулан үндэсний болон олон улсын холбогдох байгууллагад гомдол гаргах, шийдвэрлүүлэх эрхтэй.

7.5. Хүүхдийн хамгаалагдах эрхтэй холбогдсон харилцааг хуулиар зохицуулна.

Хүүхэд нь нас биенд хүрэх явцдаа дээрх эрхүүдийг эдэлдэг бол дараах үүргүүдийг биелүүлэн нийгмийн амьдралд оролцох, төлөвшин хүмүүжих үүрэгтэй байдаг байна.

9 дүгээр зүйл. Хүүхдийн хүмүүжил, төлөвшил

9.1. Хүүхдийг хүмүүжүүлэх нь хүүхдэд бие хүний сайн сайхан шинж байдал зөв үйл, ёс суртахууны үнэт чанарыг төлөвшүүлэх тасралтгүй үйл ажиллагаа байх бөгөөд хүүхдийг хүмүүжүүлэхэд дараахь чиглэлийг баримтална:

9.1.1. эцэг эхээ хайрлах, бусдыг хүндэтгэх, туслах;

9.1.2. эх орон, байгаль орчноо хайрлан хамгаалах;

9.1.3. зохих насанд нь сургуулийн өмнөх, бага, дунд боловсрол эзэмшүүлэх;

9.1.4. хууль ёсыг сахих, үндэсний өв уламжлалаа дээдлэн хүндэтгэх;

9.1.5. эрүүл мэнд болон өөрийгөө хамгаалах, амьдрах арга ухааны дадал, чадвар эзэмшүүлэх; Эх сурвалжууд. (Английн судлаач Lisa Harker болон Shelter нарын хамтран гаргасан "Chance of a lifetime" (COAL) судалгаа).

1.3. ХҮҮХДИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Хүүхдийн аюулгүй байдал гэдэг нь хүүхэд эсэн мэнд амьдрах орчин нөхцөлийг хэлнэ.

Хүүхдийн аюулгүй байдлын стандарт: “Хүүхдийн хөгжил хамгааллын стандарчлалын техникийн хороо”-ноос хүүхдийн эсэн мэнд амьдрах хөгжих хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох хүүхдийг хүмүүжүүлэх, төлөвшүүлэхтэй холбоотой эрүүл ахуй орчны болон гэр бүл боловсрол эрүүл мэнд хэвлэл мэдээлэл цахим орчин болон олон нийтийн аргахэмжээ хүүхдийн тоглоомын талбай үзвэр үйлчилгээн дэх хүүхдийн хамгааллын үйлчилгээнд хүүхдийн эрхийн хэм хэмжээг тогтоосон үйл ажиллагааны цогц юм.

Хүүхэд хамгааллын тухай хуулиас ² 2 дугаар зүйл. 2.1. Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүүхэд хамгааллын үндсэн зарчим, стандартыг удирдлага болгоно.³ 2.2. Хүүхэд хамгаалал нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэрээс, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх зорилготой олон талт, цогц, мэргэшсэн үйл ажиллагаанаас бүрдэнэ.

³ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11709>

Хүүхдийн эрхийн тухай конвенц ³

6-р дугаар зүйл

1. Оролцогч улсууд хүүхдийн амьд явах жам ёсны эрхийг хүлээн зөвшөөрнө.
2. Оролцогч улсууд хүүхдийн амьдрах, эсэн мэнд хөгжих бололцоог дээд зэргээр бүрдүүлэн хангана.

24-р дүгээр зүйл

1. Оролцогч улсууд боломжийн дээд түвшинд эрүүл байх, эрүүл мэндийн нөхөн сэргээх, өвчнийг эмчлэх нөхцөл бололцоо, арга хэрэгслээр хангагдах хүүхдийн эрхийг хүлээн зөвшөөрнө. Оролцогч улсууд эрүүл мэндийн ийм үйлчилгээ хүртэх эрхийг хөсөрдүүлэхгүй байх талаар хүчин чармайлт гаргавал зохино.

2. Оролцогч улсууд энэхүү эрхийг бүрэн хэрэгжүүлж дараахь арга хэмжээг авна:

(a) нялхсын болон хүүхдийн эндэгдлийн түвшинг бууруулах

(b) нэн тэргүүнд анхан шатны эмнэлэг-ариун цэврийн тусламжийг өргөжүүлэхэд анхаарлаа хандуулан бүх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, эмнэлгийн зайлшгүй шаардлагатай тусламжийг үзүүлэх;

(c) хүрээлэн байгаа орчин бохирдох эрсдэл, аюулыг анхааралдаа авч, анхан шатны эмнэлэг-ариун цэврийн тусламжийн хүрээнд ундны цэвэр ус, тэжээллэг хоол хүнсээр хангах, бэлэн технологи ашиглах замаар өвчин эмгэг, хоол тэжээлийн дутагдалтай тэмцэх;

(d) төрөхийн өмнө болон төрсний дараа эрүүл мэндээ хамгаалуулах зохистой үйлчилгээгээр жирэмсэн эхчүүдийг хангах;

(e) хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл, хөхөөр хооллохын давуу тал, эрүүл ахуй, амьдрах орчны ариун цэвэр, осол аюулаас урьдчилан сэргийлэх талаархи мэдээллээр нийгмийн бүх давхарга, түүний дотор эцэг эх, хүүхдийг хангах, түүнчлэн энэ талын боловсролтой болох, суурь мэдлэгээ ашиглахад дэмжлэг тусалцаа үзүүлэх;

(f) эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ, эцэг эхчүүдэд зориулсан удирдамж заавар, гэр бүл төлөвлөлтийн боловсрол, үйлчилгээг хөгжүүлэх шаардлагатай арга хэмжээг авна.

3. Оролцогч улсууд хүүхдийн эрүүл мэндийг хохироох уламжлалт дадлыг устгах зорилгоор үр нөлөөтэй бөгөөд зохистой бүх арга хэмжээг авна.

4. Оролцогч улсууд энэ зүйлд хүлээн зөвшөөрсөн эрхийг аажмаар бүрэн хэрэгжүүлэх зорилгоор олон улсын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжиж, хөгжүүлнэ. Үүнтэй холбогдуулан хөгжиж буй орнуудын эрэлт хэрэгцээнд онцгой анхаарал хандуулна.

Хүүхдийн эрхийн тухай хууль ⁴

18 дугаар зүйл. Иргэн, хуулийн этгээдийн үүрэг, оролцоо

18.1.2. хүүхдэд эрүүл аюулгүй, ээлтэй орчин бүрдүүлэхэд санаачлага гаргах, дэмжих;

5 дугаар зүйл. Хүүхдийн эсэн мэнд амьдрах эрх

5.2. Хүүхэд эрүүл өсч бойжих, аюулгүй орчинд амьдрах, аливаа хүчирхийллээс ангид байх эрхтэй.

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх НҮБ-ын судалгааны бие даасан шинжээч Пауло Сержио Пинхайро үзсэнээр:

Хүүхдийн аюулгүй байдлыг хангах стандарт нь 4 чиглэлийг хамардаг. Үүнд:

Стандарт бодлого №1 /Бодлого/

Энэхүү бодлого нь НҮБ-ын хүүхдийн эрхийн конвенцид заасан хүүхдийн хүчирхийлэл мөлжлөгөөс хамгаалах эрхийг тусгасан болно.

Стандарт бодлого №2 /Хүн/

Хүүхдийн эрхийн байгууллага ажилтнууд болон хамтрагчиддаа хүлээх үүрэг хариуцлага тэдгээрийг ойлгож эдгээрийн дагуу ажиллахад дэмжлэг үзүүлдэг.

Стандарт бодлого №3 /Журам/

Байгууллага нь байгууллага даяар хэрэгжиж буй хүүхэд хамгааллын журмыг хэрэгжүүлснээр хүүхдийн аюулгүй орчныг бүрдүүлдэг. Хүүхдийг хамгаалах эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийг бууруулах стратеги нь одоо байгаа бүх түвшний эрсдэлийн үнэлгээний үйл явцад тусгагдсан байдаг. Хүүхэд хамгааллын арга хэмжээ нь одоо байгаа үйл явц, системтэй (стратегийн төлөвлөлт, төсөвлөлт, ажилд авах, хөтөлбөрийн мөчлөгийн удирдлага, гүйцэтгэлийн удирдлага, ⁴худалдан авалт, түншлэлийн гэрээ болон удирдлагын систем гэх мэт). Орон нутгийн хэмжээнд тохирсон осол, асуудалд тайлагнах, хариу арга хэмжээ авах үйл явцыг боловсруулдаг.

Стандарт №4 /Хариуцлага/

⁴ *Keeping children standarts*

Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх ба журамд тогтмол хяналт тавьдаг. Практик туршлагаас суралцах нь хүүхдийг хамгаалах арга хэмжээний бодлого, өөрчлөлтийн талаар мэдээлэл өгдөг. Бодлого, үйл ажиллагааг тогтмол хугацаанд хянаж, гурван жил тутамд хөндлөнгийн үнэлгээч/аудитор албан ёсоор үнэлдэг.

1.4. ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД, ЭРҮҮЛ АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГ

Эрүүл орчин гэж юу вэ?

Гол төлөв байгалийн тэнцэл, хүрээлэн буй орчны төлөв байдалтай, холбоотой. Тухайлбал ус, агаар, газар, хөрс, түүнтэй холбоотой үүсэх хүний эрхийн асуудлын хамруулна.

Аюулгүй орчин гэж юу вэ?

Нийгэм-улс төрийн шинжтэй ойлголтыг илэрхийлэх бөгөөд тухайлбал, хүчирхийллээс ангид байх, олон нийтийн хэв журмыг хангах, бие махбодийн аюулгүй байдал, нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг бүрдүүлэх асуудлыг хамруулна. (Хүний эрхийн товч тайлбар толь 2012. Хууд 135)⁵

Хүмүүсийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх нь хүний амьд явах эрх, эрх чөлөөний үндэс юм. Хүн өөрөө байгалийн амьтан, эд эс нь болохоор түүнд цэвэр агаар, цэнгэг ус, эрүүл хөрс, эрүүл хүнс нэн тэргүүнд чухал. Тиймээс иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг зөвхөн төр гэлтгүй хувийн хэвшил ч хангах үүрэгтэй.

Эрүүл хүүхэд гэж хэн бэ? Эрүүл хүүхэд төрж, өсөхөд эцэг эх нь бие болон сэтгэцийн хувьд эрүүл байхаас гадна хүүхэд төрөхийн өмнөх үе, төрөх үе, төрсний дараах үеийн хөгжил хэрхэн явагдсантай шууд холбоотой.

Хүүхдийн өвчлөлд нөлөөлж буй шалтгаан

Агаарын бохирдол ба Хүүхдийн эрүүл мэнд. ***НҮБ-ын Хүүхдийн Сангийн Гүйцэтгэх захирал асан Энтони Лэйк (2016).***

Нягтрал 2016 онд 256 мг/м байсан нь агаарын чанарын тухайд мөрдөх ДЭМБ-ын удирдамжид заасан үзүүлэлтээс даруй 25 дахин давсан тоо юм⁹. Нарийн ширхэгт PM2.5 тоосонцрын нягтрал гэр хороололд бүр ч илүү өндөр байна¹⁰. Цаашилбал, Улаанбаатарын агаарын бохирдол нь улирлын чанартай бөгөөд 11-ээс 3 дугаар сар хүртэл маш өндөр байдаг. Энэ нь гэр хороололд нүүрс, био түлш түлдэг, мөн уурын зуух олноор ашигладагтай холбоотой. Улаанбаатар хот уулаар хүрээлүүлэн хөндийд байршдаг, өвөл цагт агаарын

⁵ Хүний эрхийн товч тайлбар толь 2012. Хууд 135

хөдөлгөөн хязгаарлагдмал байдаг нь агаарын бохирдлыг улам даамжруулдаг¹¹.

Агаарын бохирдол хүүхдийн эрүүл мэндэд эхийн хэвлийд бий болсон цагаас нь эхлэн сөргөөр нөлөөлдөг. Монголд ургийн эндэгдэл өвөл, зуны улирлын хоорондох ялгаа 3.5 дахин зөрүүтэй байна¹². Сүүлийн 10 жилийн хугацаанд 10 000 хүнд ногдох амьсгалын замын өвчлөл огцом нэмэгдэж 2.7 дахин өссөн гэх тооцоо байна¹³. Өнөөдрийн байдлаар уушгины үрэвсэл 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 2 дахь шалтгаан болоод байна¹⁴.

2015 онд 5 хүртэлх насны 435 хүүхэд уушгины үрэвслийн улмаас нас барсан¹⁵. Улаанбаатар хотын агаарын бохирдол өндөртэй төв дүүрэгт оршин суудаг хүүхдүүдийн уушгины багтаамж хөдөө орон нутагт амьдардаг хүүхдүүдийнхээс 40 хувиар бага байна.

Иймээс Улаанбаатар дах агаарын бохирдлын түвшин маш өндөр, иргэдийн эрүүл мэнд, эсэн мэнд амьдрахад сөргөөр нөлөөлж байгаа нь нийт хүн амын бараг тал нь амьдарч байгаа Улаанбаатар хотын хувьд онцгой байдлын түвшинд хүрчээ. Өмнө нь дурдсанчлан, мөн энэхүү тайланд хийсэн дүн шинжилгээнээс үзэхэд Улаанбаатар хотын агаарын бохирдол хотын иргэдийн эрүүл мэндэд ихээхэн хэмжээний хохирол хэдийн учруулаад байна.


Бүтцийн шинж чанартай өргөн хүрээг хамарсан дорвитой арга хэмжээ авахгүй бол агаарын бохирдлын түвшин цаашид ч нэмэгдэх төлөвтэй байна. Гэтэл энэ хооронд Улаанбаатар хотод өвлийн улиралд агаарын бохирдлоос улбаалсан хүүхдийн өвчлөл, нас баралт нэмэгдсээр байна. Иймд үүссэн нөхцөл байдлыг онцгой байдал гэж үзээд МУЗГ, бодлого боловсруулагчдын зүгээс хэрэгжүүлж болох бүх арга хэмжээг нэн дарай авах шаардлагатай гэж шинжээчид үзжээ.⁶

Монгол Улсын эх хүүхдийн өвчлөл, эндэгдлийн байдал, бүрдэл судалгаа

Хүүхэд, өсвөр насныхны эрүүл мэнд:

Монгол улсад 2020 оны байдлаар 1.114.5 мянган 15 хүртэл насны хүүхэд байгаа бөгөөд нийт хүн амын 33.2 хувийг эзэлж байна. Үүнээс 5 хүртэлх насны хүүхэд 12.0 хувь, 5-9 насны хүүхэд 11.2 хувь, 10 хувийг 10-14 насны хүүхэд эзэлж байна.

⁶ НҮБ-ын Хүүхдийн Сангийн Гүйцэтгэх захирал асан Энтони Лэйк (2016)




Зураг 2. Хүн амд эзлэх хүүхдийн тоо, хувь

Хүүхдийн эрүүл мэнд, тусламж үйлчилгээний үзүүлэлт:

2020 оны байдлаар хүүхдийн эмчээр мэргэшсэн нийт 725 эмч 18 хүртэлх насны хүүхдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд нэг эмчид 1537 хүүхэд ногдож байна.

Зураг 3. 21 Хүүхдийн эмчийн тоо, сонгосон онуудаар



2010 онтой харьцуулахад хүүхдийн эмчийн тоо 231-ээр нэмэгдсэн байна.

Хүүхдийн эмчийн тоо жил дараалан нэмэгдэж байгаа хэдий ч нэг эмчид ногдох хүүхдийн тоо өндөр хэвээр байгаа. 2014, 2015 онд хүүхдийн тооноос


хамаараад харьцангуй бага байгаа хэдий ч цаашид энэ тоо нэмэг⁷дэх хандлагатай байна. Нэг хүүхдийн эмчид ногдох хүүхдийн тоо бүсээр харьцуулан харахад ялгаатай байгаа ба зүүн бүсэд хамгийн өндөр буюу улсын дунджаас 314 хүүхдээр их байна.

2020 оны байдлаар Улаанбаатар хотод улсын дунджаас бага, хөдөө орон нутагт буюу бүх бүсүүдэд улсын дунджаас өндөр байна. Аймгуудаар харьцуулан харвал Орхон, Өмнөговь, Хэнтий, Архангай, Завхан, Дорноговь аймгуудад улсын дунджаас бага байна.

Стационарын тусламж үйлчилгээ

1990 онд эмнэлэгт хүүхдийн хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээнд ашиглаж буй орны тоо 6384 байсан ба нийт эмнэлгийн орны 24.2 хувийг эзэлж байсан. 2010 он хүртэл хүүхдийн орны тоо буурч 2315 буюу нийт орны 13.0 хувийг эзэлж байсан ба түүнээс хойш аажмаар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

2020 оны байдлаар хүүхдийн орны тоо 3642 байгаа нь нийт улсын хэмжээнд ажиллаж байгаа орны 13.4 хувийг эзэлж байна. Хүүхдийн орны 28.6 хувь нь сум, тосгоны эрүүл мэндийн төвд, 26.9 хувь нь нийслэлийн дүүргийн нэгдсэн эмнэлэгт, 16.3 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт, 14.3 хувь нь хувийн эмнэлэгт, 6.3 хувь нь бүсийн оношлогоо, эмчилгээний төвд, 5.9 хувь нь төрөлжсөн мэргэшлийн төв, тусгай мэргэжлийн төвүүдэд, 1.6 хувь нь бусад эмнэлэгүүдэд ажиллаж хүүхдийг хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээг үзүүлж байна.



2020 оны байдлаар 135.9 мянган хүүхэд эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн нь нийт хэвтэн эмчлүүлсэн хүний 16%-г эзэлж байна. Нялхас болон тав хүртэлх

⁷ Эрүүл мэндийн үзүүлэлт 2020-он судалгаа

насны хүүхдийн өвчлөл хот, хөдөөд амьсгалын тогтолцооны өвчин тэргүүлэх шалтгаан болж байна. Нялхас болон тав хүртэлх насны хүүхдийн дунд тохиолдох амьсгалын тогтолцооны өвчлөлөөс уушгины хатгалгаа 25.4 хувь, цочмог амьсгуурстас 21.0 хувь, томуу, томуу төст өвчлөл 10.9 хувийг тус тус эзэлж байна. Хоол боловсруулах тогтолцооны өвчлөлийн дийлэнх буюу 48.5 хувийг халдварт бус суулгалт өвчин эзэлж байна. Өсвөр насны хүүхдийн өвчлөлд амьсгал, хоол боловсруулах тогтолцооны өвчлөл ба гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг, арьс арьсан доорх эслэгийн өвчлөл, шээс бэлгийн тогтолцооны өвчлөл, халдварт ба шимэгчит зарим өвчин тэргүүлэх шалтгаан болж байна.

1.5. ХҮҮХДИЙН БОЛОВСРОЛ БА ХӨГЖИЛ

Хүүхдийн хөгжил гэж юу вэ? Энэхүү асуудлаар судлаачид өөр өөрийн тодорхойлолтыг өгсөн байдаг байна. Тухайлбал: АНУ-ын сэтгэл зүйч Грейс Крайг "Хөгжил бол хүний бие махбодид явагдаж буй биологийн процессуудын улмаас мөн хүрээлэн буй орчны нөлөөллөөр хүний бие махбодь, сэтгэц, зан байдалд гарч буй өөрчлөлт юм" хэмээжээ. АНУ-ын сэтгэл зүйч Нора Ньюкомб "хөгжил бол хүний бие махбодь, сэтгэц, сэтгэл хөдлөл, харилцаа болон зан байдалд гарч буй хаьцангуй тогтвортой өөрчлөлт юм" гэжээ.

Хүүхэд түүний хөгжлийн тухай онол үзэл баримтлал

Прагматизмийн үзэл. Энэ үзэл нь XIX-XX зууны зааг дээр гарч ирсэн. Үндэслэгч нь У.Джеймс, Д.Дьюи нар байв. Уг үзлийн гол санаа бол бие хүний хөгжилд түүний зөн билиг, төрөлхийн авъяас чадавх голлох үүрэгтэй гэсэн санаа юм.

Неопозитивизм. XIX-XX зууны зааг дээр гарч ирсэн. Үндэслэгч нь Бертран, Рассел, Морган нар байв. Энэхүү үзлийн гол санаа бол байгалийн шинжлэх ухааны үндэс бол туйлын үнэн учраас хүний хөгжилд голлох байр суурь эзэлнэ гэсэн зүйл юм.

- Монголчуудын хүнээр хүн хийж ирсэн уламжлалаас суралцсан.
- Сурагчийн сурлагын хоцрогдлыг хэрхэн арилгах вэ? гэдэг тал дээр мэдээлэлтэй болсон.
- Хүмүүжлийн доголдолтой хүүхэдтэй хэрхэн яаж харьцах арга зүйг судалсан.
- Сурагчдын бүлэг, хамт олон дотор үүсдэг зөрчлийг хэрхэн шийдэх талаар мэдээлэл авсан.

Хүүхдийн эрхийг олон улсад хэрхэн хамгаалдаг вэ?

НҮБ-аас баталсан Хүүхдийн эрхийн тухай конвенци болон түүний нэмэлт 3 протокол нь бүх хүүхдийн эрхийг хамгаалдаг олон улсын гэрээ юм. Эдгээр нь; Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт протокол, Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт протокол, Мэдээлэл хүргүүлэх журмын тухай хүүхдийн эрхийн конвенцийн 3 дугаар нэмэлт протокол, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг НҮБ-ын Хүүхдийн конвенциос гадна НҮБ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенциор давхар хамгаалдаг. Эдгээр нь Монгол улсад нэгэн адил хэрэгжихийг шаарддаг.

Хүүхдийн оюуны хөгжлийг олон улсад үндсэн 3 хэсэгт ангилдаг байна.

1. Танин мэдэхүйн хөгжил: Энэ бол хүүхдийн суралцах, аливаа асуудлыг шийдэх чадвар юм.
2. Нийгэм ба сэтгэл санааны хөгжил: Энэ бол бусадтай харилцах, өөрийгөө удирдахад туслах чадвар юм.
3. Хэл ярианы хөгжил: Энэ бол хүүхэд хэлийг ойлгож, хэрэглэх чадварыг хэлнэ. Дэлхийн хөгжилтэй орнууд хүүхдүүддээ эдгээр 3 хөгжлийг зэрэг хөгжүүлэхийг зорьдог бөгөөд цэцэрлэг, сургуульд нь насанд тохирсон хөгжлийн хөтөлбөрүүд ордог байна.

Жишээ нь I-III дугаар ангид нь хүүхдийн танин мэдэхүйн хөгжлийг хөнгөн сонирхолтой байдлаар орох ёстой гэж үздэг бөгөөд хүүхдийг өөрийгөө зөв илэрхийлэх, зоригтой байх, хүлээцтэй байх зэрэг эмоцийн илэрхийллүүдийг илүүтэйгээр зааж сургадаг байна. Монгол сургуулиудаас ялгаатай нь гадаад сургуулиуд хүүхэд бүрийн хөгжлийг анхаарч хэдий ангиар хичээл ордог ч хувийн үйлчилгээг хүүхэд бүрд, гэр бүл бүрд үзүүлж чаддагаараа ялгарч байгаа юм байна. Харин манай сургалтын систем нь хүүхдийг онолын боловсрол эзэмшүүлэх талруу нь түлхүү анхаардаг 1-3 дугаар ангидаа хүүхэд маш олон цагийн математик, хэлний хичээлүүдийг авдаг бөгөөд харилцаа, эмоцийн хувьд томоотой, даруу төлөв байхыг л зааж сургадаг байна. Заримдаа энэ нь хүүхдийг хэт баригдмал болгодог.

Э.Эриксон 6 насыг хүүхдийн тоглох нас гэж үзсэн бөгөөд доорх зөвлөмжүүдийг гаргасан байдаг. Зургаан насны эхэн үед хүүхдийн тоглоом орчноо танихад чухал үүрэгтэйг анхаарч тоглоомын явцад өрнөж байгаа хүүхдийн бие даасан байдал идэвхийг дэмжиж өгөх, хүүхэд юманд сониучхан бүтээлч хандах эрхтэй гэдгийг хүлээн зөвшөөрөх.

Монгол Улсын Үндсэн хуулинд төр нь хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хүлээсэн ёсоор Хүүхдийн эрхийн тухай конвенц, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг соёорхон, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль зэргийг батлан хэрэгжүүлж эхэлсэн.

Хүүхдийн эрхийн тухай хуулиар хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн бүрэн эрхийг тодорхойлж,

хүүхдийн эрхийг хангах тогтолцоог бий болгох, хүүхдийн эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг.

Хүүхэд хамгааллын тухай хуулиар хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо, оролцогч талуудын харилцааг тодорхойлж хүүхдийг үл хайхрах байдал, дарамт, мөлжлөг хүчирхийллийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөл байдалд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг. Мөн хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалаар батлан гаргасан хууль, холбогдох дүрэм журмуудаар хүүхдийн эрхийг хамгаалдаг.

Хүүхдийн эрхийн тухай хууль: 13 дугаар зүйл.

Хүүхэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Энэ нь төрөл бүрийн мэдээлэл, үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр хэвлэмэл буюу урлагийн бүтээлийн хэлбэрээр, хүүхдийн сонгосон мэдээллийн бусад арга хэрэгслээр эрэх, олж авах, дамжуулах эрх члөөг багтаана.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай:

- 28 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг баталгаажуулжээ.
- 28.1. Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, оношлох, үнэлэх, тэдэнд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн бусад үйлчилгээг гэр бүл, хамт олонд нь түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, хүүхдийн хөгжлийн төвийг байгуулан, хөгжлийн хоцрогдолтой хүүхдэд тусгай хөтөлбөрийн дагуу үйлчилгээ үзүүлэхийг төрөөс дэмжинэ.
- 28.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд эрүүл мэнд, боловсрол болон сэргээн засах үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлнэ.
- 28.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг нийгмийн хамгааллын болон нийгмийн халамжийн тусламж, үйлчилгээнд хамруулна.
- 28.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, бүх төрлийн дарамт, мөлжлөгт өртөх, гэмт хэргийн хохирогч болох, гэмт хэрэгт татагдан орох зэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хууль сахиулах, хүүхдийн эрхийг хамгаалах, боловсролын болон төрийн эрх бүхий холбогдох байгууллага хэрэгжүүлнэ.
- 28.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй холбоотой аливаа бодлого, шийдвэрийг гаргах явцад тэднийг үзэл бодлоо илэрхийлэх боломжоор хангана.
- 28.6. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хүүхдээ өсгөн бойжуулах, хөгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, чадвар олгоход төрөөс дэмжлэг үзүүлнэ.
- 28.7. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүргийг тэдний эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хүлээх бөгөөд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх хуулиар хүлээлгэсэн үүргээ биелүүлэхээс зайлсхийхийг хориглоно.

- 28.8. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэрлэгчид гэрлэлтээ цуцлуулсан тохиолдолд тэтгэлэг төлөгч нь холбогдох хууль тогтоомжинд заасны дагуу нэмэлт тэтгэлэг төлнө.

1.6. ХҮҮХДИЙН ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛ ХҮМҮҮЖЛИЙН АЖИЛ

Чөлөөт цагаа өнгөрөөх үйл ажиллагаа нь өөрийгөө боловсрол, өөрийгөө тодорхойлох хүрээ юм. Тэр дундаа өсвөр насныхны чөлөөт цаг бол тэдний эрх чөлөө, бие даасан байдал, идэвхтэй үйл ажиллагаа, өөрийгөө илэрхийлэх байгалийн хэрэгцээгээ ялангуяа хурц бөгөөд бүрэн илэрхийлдэг салбар юм. Орчин үеийн нийгэм-соёлын нөхцөлд өсвөр насныхны чөлөөт цагийг өнгөрөөх нь нийгмийн ухамсартай хэрэгцээ болж байна.⁸ (*НҮБ, Хүүхдийн эрхийн конвенц 1-р зүйл*)

Өнөөгийн байдлаар өсвөр үеийнхний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх үйл явцад сургууль, соёлын байгууллага, гэр бүлийн ажил нь орчин үеийн нийгмийн тулгамдсан асуудал болоод байна. Залуу үеийнхний чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх соёлыг төлөвшүүлэхэд энэ асуудлыг бүрэн хамруулах шаардлагатай байна.

Боловсрол, хүмүүжлийн систем дэх гэр бүл. Энэ нь амаргүй, учир нь одоо ардын сурган хүмүүжүүлэх ухааны үзэл санаа бараг алдагдаж байна. Ардын мэргэн ухаанаас төрсөн хүмүүжлийн талаарх санаа зовнил, орчин үеийн хүмүүжлийн онолын үндсийг эцэг эхийн мэдлэг бага, санамсаргүй. Гэр бүлийн амралт чөлөөт цагийг зохион байгуулахад нийгэм, соёлын байгууллагууд, сургуулиудын идэвхтэй оролцоо нь практикаас харахад чөлөөт цагийг нийгмийн идэвхгүй байдал, гэр бүлийн зарим хэсгийг даван туулах, систем доторх зөрчилдөөнийг саармагжуулах, дутагдлыг сэргээх чухал хүчин зүйл гэж үзэх боломжийг олгодог. Харилцан итгэлцэл, олон хувилбар, тэр дундаа гэрийн чөлөөт цагаа өнгөрөөх үйл ажиллагааг хэрэгжүүлэх таатай боломжийг бий болгож байна.

Гэр бүлтэй ажиллах соёл, амралт чөлөөт цагийн хэлбэрүүдийн үнэ цэнэ нь хүүхэд. Гэр бүлийн нийгмийн чадавхийг ашиглах үр нөлөө нь эцэг эхийн сурган хүмүүжүүлэх соёлын чөлөөт цаг, түүний зохион байгуулалтын технологи нь хувь хүний хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг. Үүнийг нэмэгдүүлэхэд сургууль, нийгмийн үйлчилгээ, клуб, номын сан болон бусад төвүүдийн хүчин чармайлт хувь нэмэр оруулдаг.⁹ (*Хүүхдийн хөгжлийн гарын авлага*).

Хүүхдийн эрхийн тухай конвенц: 13-р зүйл¹⁰

1. Хүүхэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрх нь төрөл бүрийн мэдээлэл, үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар,

⁸ “Бага насны хүүхдийн цогц хөгжил” unicef

⁹ Хүүхдийн хөгжлийн гарын авлага

¹⁰ Хүүхдийн эрхийн тухай конвенц

бичгээр, хэвлэмэл буюу урлагийн бүтээлийн хэлбэрээр, хүүхдийн сонгосон мэдээллийн бусад арга хэрэгслээр эрэх, олж авах, дамжуулах эрх чөлөөг багтаана.

2. Энэ эрхийг хэрэгжүүлэхэд зарим хязгаарлалт тогтоож болох бөгөөд энэ нь хуульд зааснаар:

(a) бусдын эрх, нэр хүндийг хүндэтгэх;

(b) үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, нийтийн эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалахад шаардлагатай байвал зохино.

Одоогийн байдлаар зөвхөн хүүхдүүдэд чиглэсэн сургуулиас гадуурх олон тооны байгууллагууд байдаг бөгөөд соёл, амралт чөлөөт цагийн төвүүд бий. Театрууд, соёлын байгууллага, сургуулийн хүчин чармайлтыг юуны өмнө гэр бүл, хамт олон, нийгмийн хамтын ажиллагааг зохион байгуулахад чиглүүлэх ёстой. Эцэг эх, хүүхдүүдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх үйл ажиллагаа нь зайлшгүй нөхцлүүдийн нэг юм.¹¹

Дүн шинжилгээ:

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхэд, Гэр бүлийн хөгжлийн газар, НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр “Үндэсний агуулгыг дэлхийд” уриатайгаар үйл ажиллагаа явуулдаг “Монгол контент” компанитай хамтран хүүхэд залуусын чөлөөт цагаа өнгөрүүлдэг газруудын талаар судалгаа явуулжээ.

Нийслэлийн хэмжээнд 2020 оны байдлаар өсвөр насныханд чиглэсэн чөлөөт цаг өнгөрүүлэх 389 газар, талбай, төв байдаг гэж бүртгэгдсэн байна. Тодруулбал, усан спортын төв 18, чийрэгжүүлэх клуб 37, хүүхдийн зуслан 22, спорт цогцолбор 22, сургалтын төв 50, үзвэр үйлчилгээний газар 44, кино театр 7, мөсөн гулгуур 23, спорт талбай 134, өдөр өнжүүлэх 50 байдаг байна. Нийслэлд 13-18 насны 53700 хүүхэд байгаа бөгөөд тэдний 30 хувь нь л дээрх газар, төвүүдээр чөлөөт цагаа өнгөрөөдөг гэсэн судалгаа байгаа юм.

Иймд өсвөр насны хүүхдүүдийн чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, хөгжлийг дэмжих орчин үйлчилгээг нэмэгдүүлэх шаардлагатай.¹² Судалгаанд хамрагдсан 90 хүүхдийн чөлөөт цагийг хэрхэн ойлгож байгаа асуудлыг судалж үзэхэд 45% нь амрах, дуртай зүйлээ хийж өөрийгөө хөгжүүлэх цаг гэж ойлгодог байхад, 33% нь зөвхөн дуртай зүйлээ хийх цаг, 13% нь өөрийгөө хөгжүүлэх, 9% нь ердөө амрах цаг гэж ойлгодог байна. (Хүүхэд гэр бүл хөгжлийн газар судалгаа 2020).

Чөлөөт цагаа өнгөрөөх харилцааны санал болгож буй хэлбэрүүдийн түвшин доогуур, соёлын байгууллагуудын материал, техникийн бааз хангалтгүй хөгжсөн. Чөлөөт цагаа зөв зохион байгуулж чадахгүй байгаа нь орчин үеийн

¹¹ Хүүхдийн эрхийн конвенц

¹² Хүүхэд гэр бүл хөгжлийн газрын 2020 оны судалгаа

өсвөр насныхныг зурагтын өмнө удаан суух, компьютерт донтох гэх мэт байдалд хүргэдэг. Суурин амьдралын хэв маяг нь бие махбодийн идэвхгүй байдлыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулдаг, хоолны дуршил алдагдах, нойр муутай байдаг. Өсвөр насны хүүхэд хайхрамжгүй, цочромтгой болж, сэтгэлийн байдал нь ихэвчлэн өөрчлөгддөг. Интернет болон виртуал харилцаа холбоог ашиглах чадвар нь жинхэнэ үе тэнгийнхэнтэйгээ харилцах чадварыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулдаггүй. Харин ч зарим нэг үгэндээ хариуцлагагүй хандсан нь хүүхдүүдийг бодит харилцаанаас улам бүр холдуулж байна.

Одоогийн байдлаар "гэрийн" хүүхдүүд эцэг эхийнхээ айдасыг төрүүлдэггүй, асуудал нь дараа нь янз бүрийн өвчин, үе тэнгийнхэнтэйгээ зөрчилдөх гэх мэт хэлбэрээр гарч ирдэг. Хийх зүйлгүй" өнөөдөр ихэнх хулигаан, халдлага үйлдэгддэг; архи, мансууруулах бодис, хортой эм хэрэглэх. Өсвөр насныхны дунд тэнүүлч хүүхдүүд, насанд хүрээгүй биеэ үнэлэгч, хар тамхинд донтогсдын тоо нэмэгдсээр байна. Олон залуусын хувьд найз нөхөдтэйгээ баар цэнгээний газруудаар тогтмол зугаалах нь тэдний чөлөөт цагийн нэг хэсэг юм. *(Эрдэм шинжилгээний бичиг).*

Чөлөөт цагийг зохион байгуулахдаа өсвөр насныхны дунд хамгийн түгээмэл байдаг, хэрэгцээтэй ажлын хэлбэрийг ашиглах шаардлагатай. Эдгээр харилцааны хэлбэрийг соёлыг төлөвшүүлэх нийгмийн үнэ цэнэтэй суваг болгон дамжуулах нь тулгамдсан асуудал юм. Тухайн бүс нутгийн онцлог шинж чанар, зан заншил, зан заншлыг харгалзан үзэж, үүнийг хэрхэн яаж хийх талаар бодох хэрэгтэй.

Эрх зүйн орчин:

Хүүхдийг амьдралд бэлтгэх, шинийг эрэлхийлсэн бүтээлч ухаанд сургах, үндэсний бахархал, зан үйл, нандин уламжлалаа өвлөн хөгжүүлэх, шударга хөдөлмөрийг эрхэмлэн дээдлэх зан чанар төлөвшүүлэх нь манай орны төр, олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн гол зорилт болж байгааг харгалзан Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгох нь:

1. Хүүхдэд зориулан соёл урлагийн үйлчилгээ явуулдаг байгууллагыг аль болохоор төрийн ивээлд байлгаж, хүүхдийн хөгжил, хүмүүжил, гоо зүйн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, тэдний нас, сэтгэхүйн онцлогт тохирсон ном хэвлэл, уран бүтээлийг олшруулах, чанарыг нь сайжруулах зорилгоор дор дурдсан нөхцөлийг бүрдүүлэх асуудлыг судалж шийдвэрлэсүгэй:

а/Монгол телевизэд хүүхдийн нэвтрүүлгийн студи байгуулах, суваг шинээр нээх, радиогийн нэвтрүүлгийн цагийг нэмэгдүүлэх;

б/улсын хүүхдийн төв номын санг зориулалтын байраар хангах;

в/сургуулийн өмнөх насны болон сургуулийн бага, дунд, ахлах насны хүүхдэд зориулсан "Оюун түлхүүр", "Залгамжлагч" сэтгүүл, "Хойчийг залгамжлагч" сонинг хэвлэхэд төсвөөс дэмжлэг үзүүлэх;

г/хүүхдийн театр-киноны хүрээлэн, Хүүхэлдэйн театр, номын сан, Радио, телевизийн нэвтрүүлгийн редакц зэрэг соёл урлагийн байгууллагын техник хэрэгсэл, төхөөрөмжийн хангамжийг сайжруулах;

д/хүүхдэд зориулсан уран зохиол, шинжлэх ухаан, танин мэдэхүйн болон орчуулгын ном, хүүхдийн уран сайхны ба баримтат кино, мультфильм, дүрс бичлэгийн кино, драмын, хүүхэлдэйн, телевиз, радиогийн жүжиг зэрэг мэргэжлийн урлагийн байгууллагын бүтээлүүдийг улсын захиалгын дагуу Соёл, урлаг хөгжүүлэх сангаас санхүүжүүлж байх; е/хүүхдэд зориулсан соёл, урлагийн байгууллагуудад ажиллах мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, гадаадын ижил төрлийн байгууллагатай хамтарч олон улсын арга хэмжээ зохион байгуулах ажлыг төвлөрсөн болон орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлж байх.¹³

2. Цэцэрлэгийн насны хүүхэд болон ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд байгаль орчноо танин мэдэх, хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх арга ажиллагаа, дадлага, туршлага, мэргэжлийн баримжаа олгох сургалтыг тогтмол зохион байгуулж байх, түүнчлэн хүн амын дунд байгаль орчныг хамгаалах сурталчилгааны ажил явуулах арга хэмжээг Монголын байгаль орчныг хамгаалах сурталчилгааны ажил явуулах арга хэмжээг Монголын байгаль орчныг хамгаалах холбоо, "Байгаль эх" төв зэрэг олон нийтийн болон бусад байгууллагатай хамтран авч ажилласугай.


3. Эцэг, эхийн хараа хяналтаас гарсан хүүхдийг халамжлан хүмүүжүүлэх, тэднийг амьдралд бэлтгэх, ажил мэргэжлийн баримжаа олгох зорилгоор Хүүхдийн сургалт, хүмүүжил-үйлдвэрлэлийн төв зохион байгуулж ажиллуулахын хамт гэр орон, эцэг эхээсээ удаан хугацаагаар дайжсан, тодорхой хаяггүй хүүхдийг эрүүл мэндийн даатгалд хамруулах, тэдэнд эмнэлгийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон асуудлыг судалж шийдвэрлэсүгэй.

4. Хүүхдийн амралт, чөлөөт цагийг бүтээлч хэлбэрээр зохион байгуулах, тэдний авьяас чадварыг нээн хөгжүүлэх, мэргэжлийн чиг баримжаа эзэмшүүлэхэд чиглэсэн хүүхдийн соёл, хүмүүжлийн ажлын материаллаг баазын ашиглалтыг сайжруулах, өргөтгөх, шинээр бий болгох арга хэмжээ авахын хамт хүүхдэд зориулсан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих, урамшуулах арга хэмжээ авсугай...

Нэмэлт судалгаа:

¹³ Монгол Улсын Засгийн газарт чиглэл


Чөлөөт цагаараа хийх дуртай зүйлс



Зураг 4. Хүүхдүүдийн чөлөөт цагаараа хийх дуртай зүйлс

Хүүхдүүдийн хийх дуртай зүйл нь PC тоглох, сагс тоглох, кино, зурагт үзэх, найз нартайгаа байх, интернет гэх мэт нэрлэсэн байна. Үүнээс харахад өсвөр насны хүүхдэд чөлөөт цагаа өнгөрүүлэх өөр орчин, үйл ажиллагаа хомс байгааг судалгааны дүн харууллаа.

Чөлөөт цагаа зөв өнгөрүүлэхэд хэрэгцээтэй зүйлс



Зураг 5. Хүүхдүүд чөлөөт цагаа зөв өнгөрүүлэхэд хэрэгцээтэй зүйлс

Судалгаанаас үзэхэд: Хүүхдүүдэд тайван орчин, тоглох газар, цаг хугацаа гэх зүйл илүү хэрэгцээтэй болох нь харагдаж байна. (2020 оны судалгаа)

1.7. ХҮҮХДЭД НЭН ШААРДЛАГАТАЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ

Хүүхдэд нэн шаардлагатай үйлчилгээний хүртээмж гэдэг нь хүүхэд эрүүл, аюулгүй, орчинд амьдарч, сурч боловсрох эрхээр бүрэн хангагдахыг хэлнэ. Хүүхдэд нэн шаардлагатай үйлчилгээнд дараах үндсэн таван ойлголтыг хамруулан ойлгож болно

- ✚ Эрүүл мэнд
- ✚ Хөгжил боловсрол
- ✚ Хүүхэд хамгаалал
- ✚ Хоол тэжээл
- ✚ Асаргаа халамж

✚ Эрүүл мэндийн үйлчилгээ

Эрүүл мэнд гэж хүн өвчин, эмгэггүй, бие бялдар, оюун санаа, нийгмийн амьдралын хувьд сайн сайхан байхыг ойлгоно. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ гэдэг нь нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээг хэлнэ. Эрүүл мэндийн байгууллага нь хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зорилго, үндсэн чиг үүрэг бүхий хуулийн этгээдийг хэлнэ.

Хууль эрх зүйн хувьд дараах байдлаар тусгасан байна. Эрүүл мэндийн үйлчилгээн дэх хүүхдийн эрхийн асуудал

7.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ хүүхдийн, түүний гэр бүл, хувийн нууцад хамаарах мэдээллийг хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд байгууллага, албан тушаалтан, хувь хүнд мэдээлэхийг хориглох бөгөөд задруулснаас үүдэн гарах үр дагаврыг өөрөө хариуцна.

7.3. Эрүүл мэндийн байгууллага эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хуульд заасны дагуу үзүүлнэ.

✚ Боловсролын үйлчилгээ

Боловсрол нь иргэний сурч боловсроход үндэс угсаа, хэл арьсны өнгө, нас хүйс, хөгжлийн онцлог, эрүүл мэнд, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгавралан гадуурхахгүй байх эх хэлээрээ сурч боловсрох тэгш боломж нөхцөлөөр хангана. (Боловсролын тухай хууль 5.1.4)

Хөгжил хүүхдийн чанартай боловсрол нь ирээдүйтэй, боловсролтой ажиллах хүчнийг бий болгоно. Бага насандаа чанартай боловсролд хамрагдаж буй хүүхэд нь сургуульд амжилттай бэлтгэгдэж, илүү сайн суралцдаг байна.

✚ Хүүхэд хамгааллын үйлчилгээ

Хүүхэд хамгаалалын үйлчилгээ гэдэг нь хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо, оролцогч талуудын харилцааг тодорхойлж, хүүхдийг үл хайхрах

байдал, дарамт, мөлжлөг, хүчирхийллийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. /хүүхэд хамгааллын тухай хууль 1.1/

Хүүхэд хамгаалал үйлчилгээний бүтэц нь хүүхдийн эрхийн талаарх төрийн бодлого, хөтөлбөр хууль болон холбогдох журмуудыг баталж үйл ажиллагааны салбар чиглэлүүдээр олон шинэ болон шинэчилсэн бүтэц зохион байгуулалт бий болсон.

Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд гэж эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин нь алдагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, эсхүл гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхэд юм.

Нийгмийн ажилтан нь баг, хорооны, сургуулийн, нийгмийн халамжийн, эрүүл мэндийн, бусад салбарт ажиллаж байгаа нийгмийн ажил, үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий мэргэжилтэн, ажилтан, албан тушаалтныг хэлнэ.

Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэж, мөрдөн шалгагдаж байгаа эсхүл гэмт хэргийн гэрч, хохирогч болсон гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагын төлөөлөл бүхий орон нутгийн нэгжийг ойлгоно.

Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ нь эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулгүй байдлыг хангах, дэмжих, холбон зуучлах, нийгмийн харилцаанд дасган зохицуулах, гэр бүлд нь эргэн нэгтгэх үе шат бүхий үйл ажиллагаа юм.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэж санаатай эсхүл санамсаргүйгээр хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжил, бие махбод, сэтгэл санаанд хор хохирол учруулах үл хайхрах байдал бэлгийн зүй бус үйлдэл болон бие махбодийн шийтгэл, сэтгэл санааны дарамтыг ойлгож болно.

Хоол тэжээлийн үйлчилгээний хүртээмж

Хоол тэжээл гэдэг нь бага насны хүүхдийн асаргаа, хамгаалал, хөгжил, боловсролыг дэмжих нийгмийн суурь үйлчилгээг хөгжүүлэх нь улс орны засгийн газруудын тэргүүлэх зорилтуудын нэг байх ёстой зүйл юм.

Бага насны хүүхдийн хоол тэжээл бол хүний амьдралын эхний 1000 хоногт нь эрүүл мэндийн суурь тавигдаж, бие эрхтэн хөгжин дархлаажиж, оюун хөгжлийн эх суурь тавигдаж, бодисын солилцооны хэтийн төлөв тодорхойлогддог. Түүнчлэн энэ хугацаанд хүүхдийн тархи, бие махбодын хөгжил нь хамгийн хурдтай явагддаг төдийгүй тэдний тархины хөгжлийг дэмжих боломжит, эгзэгтэй цонх үе байдаг.

Хууль эрх зүйн орчинд дараах байдлаар тусгагдсан Монгол Улсын Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хууль: УИХ-ын тогтоол, 2017 оны 5 дугаар сарын 12 өдөр • “Хүн амын хоол тэжээл” үндэсний хөтөлбөр, Монгол Улсын

Засгийн газрын 2015 оны 11 дүгэр сарын 16-ны өдрийн 447 дугаар тогтоол • Нялх балчир хүүхдийг хооллох заавар, Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/481 тоот тушаал • Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр, Эрүүл мэндийн сайдын 2010 оны 34 тоот тушаал, 2013 оны 450 тоот тушаал (эрүүл мэндийн статистик мэдээллийн талаар авах зарим арга хэмжээний тухай) • Эрүүл мэндийн сайдын 2013 оны 100 дугаар тушаал: “Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийн зөвлөмж хэмжээ, заавар”, “ЭМЯ-ны дэргэдэх Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийн хангамж, 1 ДЭМБ, НҮБХС-аас “Нялх, бага насны хүүхдийн хооллолтын дэлхийн стратеги” болон “Эхийн сүүгээр хооллодог нялх, бага насны хүүхдийн нэмэгдэл хооллолтын удирдамж”, “Гамшиг, онцгой байдлын үед нялх, бага насны хүүхдийг хооллох удирдамж”, “Эхийн сүүгээр хооллодоггүй 6-23 сартай хүүхдийг хооллолтын удирдамж” зэрэг суурь баримт бичгийг боловсруулж, гишүүн орнуудад хэрэгжүүлэхийг зөвлөсөн байна.

Бага насны хүүхдийн асаргаа, халамж

Бага насны хүүхдийг асарч халамжлах нь хүүхдийн хөдөлгөөн, дуу авиа, дохио зангаа, үг хэллэгийг ажиглах ойлгож нийттэй хариу үйлдэл үзүүлэхээс эхэлнэ.

Бага насны хүүхдийг асарч халамжлах нь :

- Хүүхдийг аюул, ослоос урьдчилан сэргийлэн хамгаалж, сөрөг үр дагаврыг зогсоох,
- Хүүхэд өвчилсөн эсэхийг мэдэх, өвдсөн тохиолдол асрах,
- Хүүхдийн танин мэдэх, сурах чадварыг дэмжих,
- Хүүхдэд итгэл бий болох, хүүхэд нийгмийн харилцаанд оролцох зэрэгт ач тустай байна.

Бага насны хүүхдийн асаргаа, халамжид хүүхдийн эрүүл хооллолт чухал байр суурь эзэлдэг. Ялангуяа хүүхэд бага жинтэй байх эсвэл өвдсөн үед хооллолт нэн чухал байдаг. Эцэг эх хүүхдээ ярьж эхлэхээс өмнө энгэртээ тэврэх ,нүдээрээ харилцан инээх, хүүхэд дуу авиа, нүүрний хөдөлгөөнд хариу үйлдэл үзүүлэх зэргээр тэдэнтэй харилцаж, ойлголцдог. Хүүхэд эхийн хэвлийд бүрэлдэх үеэс эцэг эх, хүүхэдтэйгээ харилцаж, ойлголцох нь хожмоо юугаар ч орлуулшгүй сэтгэлийн нарийн нандин холбоосыг бий болгодог. Улмаар энэхүү нарийн харилцаа холбоос бага насны хүүхдийн тархины хөгжлийг дэмжих нэг чухал хүчин зүйл болдог.

Бага насны хүүхдийн асаргаа халамжийг дэмжих арга зүй.

Шинэ төрсөн хүүхэд амьдралын эхний саруудад юу хүсэж, юу хэрэгтэй байгааг таньж мэдэх нь хязгаарлагдмал төдийгүй олон талаар насанд хүрэгсэд, асран хамгаалагчдаас хараат байдаг. Энэ байдал нь хөгжлийн явцад удаан үргэлжлэхгүй хэдий ч тав хүртэлх насанд эрүүл хооллох, аюулгүй байдлаа хангаж, хамгаалах бусадтай харилцана. Нийгмийн амьдралд оролцох, шинийг таньж мэдэх, туршлага хуримтлуулах, сэтгэл хөдлөлөө удирдах зэрэгт тэдэнд

эцэг, эх, асран хамгаалагчийн тусламж дэмжлэг нэн чухал байсаар байх болно. Эцэг эх хүүхдийнхээ юу хүсэж, нөхцөл байдал нь ямар байгааг сайтар ойлгож, хялбар таньж мэддэг хэдий ч хэрхэн хариу үйлдэл үзүүлэх вэ? гэдэгт тулгамдах хэн нэгнээс тусламж дэмжлэг авах хэрэгцээ үүсч байдаг.

Бага насны хүүхдийн асаргаа халамжийг сайжруулахын тулд:

- Эцэг, эх, асран хамгаалагчийн хүүхдээ хэрхэн асаргаа, халамжид ажиглалт хийж, хэрхэн сайжруулах талаар зөвлөх, туслах дэмжих,
- Эцэг эх, асран хамгаалагчийг урамшуулах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх зарчмаар тэдэнд итгэл төрүүлэх, хүүхэдтэйгээ дотно сайхан харилцах, ярилцах, тоглох,
- Эцэг эх, хүүхдийн харилцааны хүрээг өргөжүүлэх, чанарыг сайжруулах, тоглоом үйл ажиллагааг зөвлөх,
- Эцэг эх, хүүхэдтэйгээ хамт өнгөрүүлэх цагийг нэмэгдүүлэх зэргийг санал болгох хэрэгтэйг судлаачид зөвлөжээ.

Эрүүл мэнд, хоол тэжээл, боловсрол, хүүхэд хамгаалал болон гэр бүлд нийгмийн үйлчилгээ үзүүлж буй бусад салбарын мэргэжилтнүүд санал зөвлөмж өгөх замаар тэдний бага насны хүүхдийн асаргаа, халамжийг сайжруулах, мэдлэг туршлагыг өргөжүүлэх боломжтой. Судалгаануудаас дүгнэвал:

- Эцэг эх, асран хамгаалагчийн асаргаа, халамж нь хүүхдийн сэтгэл санааг тайвшруулах, хүүхэд өөрийгөө таньж мэдэх, өөрийгөө зохистой илэрхийлэх, нийгэмшихэд нь туслах, улмаар орчноо танин мэдэх, хөгжиж боловсрох, нийгмийн амьдралд оролцох чухал ач холбогдолтой.
- Эрүүл мэнд, боловсрол, хоол тэжээл, хүүхэд хамгааллын салбарын мэргэжилтнүүд, эцэг эх, асран хамгаалагчдад дэмжих үйлчилгээ үзүүлэхдээ тэдний хүүхэдтэйгээ хэрхэн харилцаж байгааг ажиглах, хүүхдэдээ сайтар асран халамжлахын ач холбогдлыг таниулан сурталчлах нь хүүхэд гэр бүлийн болон нийгмийн хөгжилд нэн тустай байдаг.

ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ХОТЫН ИНДЕКС ТОГТООХ СУДАЛГАА

Хоёр. Бодлого, эрх зүйн орчин, үйл ажиллагааны өнөөгийн байдал

Судалгааны ажлын энэ хэсэгт хүүхдийн нийгмийн оролцоо, хүүхдийн боловсрол, хөгжлийн хүүхдийн сурч боловсрох эрх, тухай олон улсын гэрээ, конвенц Монгол Улсын хууль тогтоомжоор хэрхэн баталгаажсан байдал, сургуульд хамрагдалтын түвшин, 1990 оноос хойш сургуулийн орчинд хүүхдийн эрхийг дээдлэх талаар гарсан эерэг өөрчлөлтүүд, сургуулийн орчинд илэрч буй хүүхдийн эрхийн зөрчлийн тухай, хүүхдийн үндсэн эрх болох сурч боловсрох эрх хангагдахгүй байгаа гол хүчин зүйлсийг тодруулан судлах болно. Мөн сургалтын агуулга, арга зүй, үнэлгээнд гарсан эерэг өөрчлөлтүүдийг авч үзэж шинжлэх болно.

1990 онд Монгол улс ардчилал, зах зээлийн тогтолцоог сонгосон. Энэ үеэс тавьсан хамгийн гол зорилгын нэг нь боловсролын салбарыг шинэчлэх, нийгмийн хөгжлийн загварт нийцүүлэн өөрчлөх явдал байв. Энэхүү зорилгыг хэрэгжүүлэхийн тулд хэд хэдэн хууль эрх зүйн баримт бичгүүдийг тухайлбал, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, Боловсролын тухай хууль, Бага, Дунд болон Дээд боловсролын тухай хуулиудыг 1995 онд Улсын Их Хурлаас батлан гаргажээ. Эдгээр хууль эрх зүйн баримт бичгүүд нь боловсролын удирдлагын хүрээнд ардчилсан, нээлттэй, ил тод байх, улсын сургуулиудын удирдлага, санхүүжилтэд төвлөрлийг сааруулах, сургуулийн менежментийг аймаг, орон нутгийн удирдлагад шилжүүлэх болон хувийн боловсролын байгууллага байгуулахад дэмжлэг үзүүлэх зэрэг зарчмыг баримталж байна. Монгол Улсын хувьд хүний эрхийн олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу Үндсэн хуульдаа сурч боловсрох эрхийг баталгаажуулж, төрөөс боловсролын талаар баримтлах бодлогоо тодорхойлж, боловсролын тухай багц хуулиа батлан мөрдөж байгаа билээ.

Монгол Улс Үндсэн Хуулийнхаа 16.7–дугаар зүйлд “Хүн бүр сурч боловсрох эрхтэй, төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй олгоно, мөн иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллуулж болно” гэж заасан байдаг. Нэг талаас, сурч боловсрох эрхийн хэрэгжилт нь чанартай боловсрол эзэмшиж чадаж буй эсэхээс хамаарна, нөгөө талаас, эрхэд суурилсан чанартай боловсрол нь хүүхдийн эрхийн боловсролыг

эзэмших гол түлхүүр билээ. Монгол улсын Үндсэн Хуулийн 16.7-дугаар зүйл заалт нь сурч боловсрох эрхийн хүрээнд эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч хүүхдэдээ улсын байгууллагаас байгуулсан сургууль төдийгүй, улсаас баталсан шаардлагыг хангаж байгаа бусад сургуулийг сонгох, өөрийн хувийн үзэл бодлын дагуу шашин болон зан суртахууны хүмүүжил олгох эрхтэй болох тухай асуудал юм. Энэ нь эцэг эхэд хүүхдэдээ боловсролын олон хувилбараас сонголт хийх боломжийг олгож байгаагаараа ач холбогдолтой.

Сурч боловсрох эрх нь хүний эрхийн олон улсын стандарт, Монгол Улсын хууль тогтоомжоор баталгаажиг хэрэгжиж байна. Сурч боловсрох эрхийг хангах, хамгаалах үүргийг Засгийн газар хүлээсэн байдаг. Хүүхэд бүр ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй эзэмших эрхтэй, суурь боловсролыг заавал эзэмших үүрэгтэй. Тухайлбал, Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлд “Боловсролын байгууллагын сургалтын орчин”, 43 дугаар зүйлд “Боловсролын харилцаанд оролцогчдын нийгмийн баталгаа”, 46 дугаар зүйлд “Эцэг, эх, асран хамгаалагчийн эрх, үүрэг”-ийн тухай тусгасан билээ.

Хүүхдийн хувьд сурч боловсрох эрхээ эдлэхдээ сургуулийн дүрэм журам, тавьсан зүй ёсны шаардлагыг биелүүлэх үүрэгтэй. Дээд шатны боловсролыг эзэмшихдээ авьяас чадварыг харгалзсан, аливаа төрлийн ялгаварлан гадуурхалтгүй тэгш боломжтой байх эрхтэй. Эцэг эх, асран хамгаалагчийн хувьд хүүхдийнхээ сургуулийг сонгох, өөрийн хувийн үзэл бодлын дагуу шашин болон зан суртахууны хүмүүжил олгох эрхтэй. Төрөөс тогтоосон стандартын шаардлагыг хангасан хувийн сургуульд төлбөртэй суралцаж байгаа нь эцэг эхийн сонголт хийх эрх чөлөөг хангаж байгаа болохоос үнэ төлбөргүй боловсрол эзэмших явдлыг зөрчиж байгаа явдал биш билээ.

Монгол Улсын Их хурлын 2016 оны 2 сарын 5-ны өдрийн дугаар 19-дүгээр тогтоолоор “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030” бодлогын баримт бичгийг баталсан. Уг баримт бичгийн 2.2.3-д “Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүн” зорилтын хүрээнд нийтдээ 5 дэд зорилтыг боловсруулсан байна. Дэд зорилт тус бүр гурван үе шаттайгаар 2016-2030 оны хооронд хийгдэх ажлуудыг тусгажээ.

Зорилт 1-д хүүхэд бүрийг стандартын шаардлага хангасан сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулж, монгол хэл, сэтгэлгээний үндсийг эзэмшүүлнэ. I үе шат (2016-2020): Сургуулийн өмнөх боловсролын тогтолцооны төрөл хэлбэрийг өргөтгөж, хүртээмж, чанарыг сайжруулан сургуулийн өмнөх

боловсролын үйлчилгээнд сургуулийн өмнөх насны нийт хүүхдийн 70 хувийг хамруулах нөхцөл бүрдүүлэх гэсэн зорилтын хэрэгжилтийг дүгнэвэл 2018-2019 оны хичээлийн жилд улсын хэмжээнд СӨБ-ийн 261354 хүүхэд байгаагаас 239764 нь буюу 91,7% нь төрийн болон хувийн хэвшлийн цэцэрлэгт хамрагдаж байна.

Зорилт 2-д Монгол иргэнийг төлөвшүүлэх ерөнхий боловсролын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, чанарыг баталгаажуулна. I үе шат (2016-2020): Боловсролын олон улсын чанарын үнэлгээнд (PISA) хамрагдах бэлтгэлийг хангаж, нийт ерөнхий боловсролын сургуулийг хоёроос ихгүй ээлжээр хичээллэх боломжийг бүрдүүлэх, уламжлалт нүүдлийн ахуйд зохицсон боловсрол олгох хөтөлбөр боловсруулж, нэвтрүүлэх гэсэн зорилтыг дүгнэж үзье.

2012-2019 оны хооронд Нийслэлийн хэмжээнд 3 ээлжээр хичээллэж буй сургуулиудыг дараах хүснэгтээр үзүүлж байна.

№	Он	Нийт сургуулийн тоо	Нийт сурагчдын тоо	3 ээлжээр хичээллэж буй сургуулиудын тоо	Бүлэг	Сурагч
1	2012-2013	207	186822	19	122	4265
2	2013-2014	203	192324	22	140	4712
3	2014-2015	213	202510	21	151	5263
4	2015-2016	214	221320	23	174	6278
5	2016-2017	225	233545	31	222	8706
6	2017-2018	241	247960	23	173	6932
7	2018-2019	245	264240	23	188	7743

Хүснэгт 1. Нийслэлийн хэмжээнд 3 ээлжээр хичээллэж буй сургуулиуд оноор, тоогоор

2018 – 2019 оны хичээлийн жилд Монгол улсын хэмжээнд ерөнхий боловсролын 803 сургууль үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 593150 хүүхэд суралцаж, 27200 үндсэн багш ажиллаж байна. Энэ хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчдаас гадна орой, эчнээ, дүйцсэн хөтөлбөрөөр нийслэлийн хэмжээнд нийт 869 суралцагч сурч байна. Үүнээс 35.2 хувь буюу 306 нь эмэгтэй сурагчид байна. Мөн хичээлийн жилд улсын хэмжээнд 94 их, дээд сургууль, коллеж үйл ажиллагаа явуулж, 157625 оюутан суралцаж байна.

Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний хувьд боловсролын үйлчилгээг тэгш, хүртээмжтэй,

амьдралд нийцсэн болгоно, хот суурин газарт хүүхэд бүр цэцэрлэгт суралцах боломжтой болж, сурагчид гэр сургуулийнхаа хооронд нийтийн тээвэрт үнэгүй зорчиж, сургууль 3 ээлжгүй болно, хөдөөд малчны хүүхэд 6-8 насандаа сонголттойгоор суралцах боломжтой болж, дотуур байрны орчин нөхцөлийг сайжруулна гэсэн ерөнхий зорилтуудыг дэвшүүлсэн байна. Хөдөө малчны хүүхэд анх сургуульд элсэхдээ 6-8 насандаа сонголттойгоор орно гэсэн заалт одоогоор хэрэгжээгүй байна.

Сургуулиудын ачааллыг бууруулах чиглэлээр 3 ээлжгүй болгох зорилт одоогоор хэрэгжээгүй бөгөөд 2017-2018 оны хичээлийн жилд улсын хэмжээнд 25 сургууль хичээллэж байгаагийн 23 нь нийслэлд байв. Ерөнхий боловсролын сургуулийн дунд ангиас ахлах анги хүртэлх насны сурагчид нийтийн тээврээр үйлчлүүлэхдээ 200 төгрөгөөр зорчиж байна.

Монгол Улсын Боловсролын тухай хууль (2002) –д заахдаа “Монгол хүн бүр үндэс угсаа, хэл, арьс, нас хүйс, нийгэм эдийн засгийн байдал, эрүүл мэнд, ажлын байр, шашин шүтлэг болон хувийн зан чанараас үл шалтгаалан өөрийн төрөлх хэлээрээ боловсрол эзэмших эрхтэй (5.1.4-р зүйл), хүн бүр суурь боловсрол эзэмших эрхтэй (6.3-р зүйл), Монгол Улсын Үндсэн хуулинд заасанчлан үнэ төлбөргүй суурь боловсрол эзэмшинэ гэж (6.2-р зүйл)-д тус тус заасан байна. Мөн одоогийн боловсролын хууль тогтоомжоор бага болон бүрэн бус дунд боловсролыг хүн бүр эзэмших бөгөөд бүрэн дунд боловсрол эзэмшихэд мөн үнэ төлбөргүй байна гэсэн зүйл заалтуудыг оруулсан нь хүүхдийн сурч боловсрох эрх хангагдах үндэс нөхцөлийг бүрэлдүүлсэн гэж үзэж болно.

Манай оронд орчин үеийн боловсролын байгууллага бүрэлдэн тогтсон 100 гаруй жилийн хугацаанд ард иргэдэд боловсрол олгох талаар багагүй амжилт олсон. Тухайлбал, 1921-1940 онд бүх нийтийг бичиг үсэгт сургах, 1941 оноос бага боловсролтой болгох, 1961 оноос бүрэн бус дунд боловсролтой болгох зорилтуудыг дэвшүүлэн 1989 оны байдлаар 16-49 насны нийт хүн амын 78.8 хувь нь бүрэн бус дунд буюу түүнээс дээш шатны боловсролтой, 12.7 хувь нь IV-VIII ангийн боловсролтой, 6.9 хувь нь бага ангийн боловсролтой, 1.6 хувь нь бичиг үсгийн боловсролтой болсон байна.

Монгол улс нь НҮБ-ын гишүүн орны хувьд хүний эрхийн олон улсын 40 гаруй гэрээ конвенцид нэгдэн орсон буюу соёрхон баталсан. Ийнхүү Монгол улс нь хүний эрхийн үзэл баримтлал, олон улсын хэм хэмжээ, стандартыг үндэсний

хууль эрх зүйн баримт бичгүүдэд тунхаглан мөн олон улсын гэрээ хэлэлцээрүүдэд нэгдэн орох замаар баталгаажуулсан хэдий ч сургуулийн орчинд хүүхдийн эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах байдалд төдийлөн ахиц дэвшил гараагүй бөгөөд хангалтгүй хэвээр байна.

Манай орны хувьд хүүхдийн сургуульд хамрагдалтын түвшин харьцангуй сайн хэдий ч чанартай боловсрол эзэмших, хүүхдэд ээлтэй сургуулийн орчин нөхцөлийг бүрдүүлэхэд төдийлөн ахиц дэвшил гарахгүй байна. Энэ нь сургуулийн орчны талаар хийгдсэн суурь судалгааны үр дүнгээр нотлогдсон юм.

Хүүхдийн эрхийг хангах, хамгаалах, сургууль, эцэг эхийн хамтын ажиллагааны талаарх эрх зүйн баримт бичгүүдийг дурдъя.

Хүүхэд хамгааллын тухай хууль 2016 оны 02 сарын 05-ны өдөр батлагдсан. Тус хуулийн 5.1-д эцэг, эх, гэр бүлийн гишүүд, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхэдтэй холбоотой эрх, үүргээ урвуулан ашиглах, хүүхдийг үл хайхрах, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэр, аливаа гэмт хэрэг, зөрчлөөс хамгаалах арга хэмжээг авна гэж заажээ.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 5.4-д Эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, хамаатан садан, багш сурган хүмүүжүүлэгч нь хүүхдийг өсгөн хүмүүжүүлэх, боловсрол олгох, асран хамгаалахдаа хүчирхийллээс ангид хүмүүжлийн арга хэрэглэнэ гэж, 8.1-д Эцэг, эх, асран хамгаалагч гэр бүлийн орчинд, багш, сургуулийн ажилтан сургуулийн орчинд, хуулиар үүрэг хүлээсэн төрийн байгууллага, хуулийн этгээд бусад орчинд өөрсдийн эрх, үүргээ хэрэгжүүлэх замаар хүүхдийг түүний хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд, сөрөг нөлөө үзүүлэхүйц тоглоом мэдээ, мэдээлэл зар сурталчилгаа, цахим сүлжээнээс хамгаална гэж тус тус заасан байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн А/239 тоот тушаалаар Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журмыг баталсан. Тус журмын 3.1-д цэцэрлэг, сургууль, дотуур байрын багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагч, суралцагчдад хүүхдийн эрх, хамгаалал, харилцаа хандлагын талаар дор дурдсан чиглэлээр нөлөөллийн үйл ажиллагааг сургууль дээр зохион байгуулна гэж заасан байна. Үүнд, 3.1.1 хүүхдийн эрх хамгааллын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, 3.1.2 хүүхэд хүмүүжүүлэх, хүүхэдтэй харилцах эерэг харилцааны аргад суралцах; 3.1.3

хүүхдэд сөрөг зан үйл төлөвшихөөс урьдчилан сэргийлж, эерэг зан үйлийг дэмжих, 3.1.4 ялгаварлан гадуурхал, ялгаатай байдлын талаарх хүүхдийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, үе тэнгийн дээрэлхэлтийг зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр хөтөлбөр боловсруулж ажиллах, 3.1.5 аливаа хүчирхийлэл, дарамт, дээрэлхэлтээс өөрийгөө болон бусдыг хамгаалах, сэтгэлзүйн бэрхшээлийг даван туулах чадвар олгох гэж тус тус заажээ.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 471 дүгээр тушаалаар Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрмийг баталсан. Дүрмийн 1.3-д сургуулийн үйл ажиллагааны үндсэн зорилт нь суралцагчдад боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх, тэдний хөгжих, төлөвших үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах, эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа дэмжлэг үзүүлэхэд оршино. Тухайлбал, 2.8-д сургуулийн үйл ажиллагааг багш, ажилтан, суралцагч, эцэг, эх, олон нийтийн оролцоотой төлөвлөж хэрэгжүүлэх, үнэлэх замаар түншлэлийг бэхжүүлнэ. 2.9-д сургуулийн үйл ажиллагаа, сургалтын үйл явц, чанар, үр дүнд өөрийн үнэлгээ өгөх чиг үүрэг бүхий багш, суралцагч, эцэг, эхийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн хяналт-шинжилгээний баг ажиллуулна. 5.9-д Эцэг, эх, асран хамгаалагч нь Боловсролын тухай хуулийн 46 дугаар зүйл, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйл, Гэр бүлийн тухай хуулийн 26 дугаар зүйлд тус тус заасны дагуу эрх, үүрэгтээ хамаарах асуудлаар сургууль болон сургалтын дотоод үйл ажиллагаанд оролцоно.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 05 сарын 01-ний өдрийн А/243 дугаар тушаалаар Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн дүрмийг баталсан. Энэ хуулийн: 4.1.5 хүүхэд болон эцэг, эх, асран хамгаалагчаас тоног төхөөрөмж, эд материал зэргийг худалдан авахыг ятгах, хууль бус орлого олохоос татгалзах, 4.2.1 хүүхдийг гэр бүлийн байдал, хөгжил, суралцах чадвараар нь ялгаварлахгүй байх, сурлагын амжилтыг бодитой үнэлэх, 4.2.2 эцэг, эх, асран хамгаалагч, олон нийт, хамтран ажиллагчдаа нас, хүйс, хувийн онцлог, албан тушаал, мэдлэг, туршлагаар нь ялгаварлахгүй, адил тэгш хүндэтгэлтэй хандах, хамт олны эв нэгдлийг дээдлэх, 4.3.1. хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, хамтран ажиллагчдыг доромжлох, нэр

төрийг гутаахгүй байх, 4.4.1 сургууль, цэцэрлэгийн нэр барьж сурагч, эцэг, эх, асран хамгаалагчаас хувийн холбогдолтой мэдээлэл гаргаж өгөхийг шаардахгүй байх, хүсээгүй мэдээллийг нь авахгүй байх, 4.4.2 хүүхдийн бие махбод, сэтгэл санааны шийтгэл үзүүлэхгүй байхаар заасан.

Сурагчдын аюулгүй байдал, сургуулийн орчны гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зам тээвэр, осол гэмтэл аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, тэдний эрх ашгийг хамгаалах, эцэг эх сургуулийн хамтын ажиллагааг улам сайжруулах, иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “School police” үйл ажиллагааг ЕБС-иуд хэрэгжүүлж байна.

Ялангуяа замын хөдөлгөөний шинэчилсэн дүрмийн 13.2.7-д заасны дагуу 10 хүртэлх насны хүүхдийг анги удирдсан багш эцэг эхэд гараас гарт өгөх ажлыг хариуцлагатай хэрэгжүүлж байна. Монгол улсын хүүхэд хамгааллын хуулийн 6-р зүйлд заасны дагуу “Ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хамгааллын бодлого”-ыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 7 сарын 31-ны өдрийн А/476 дугаар тушаалаар батлан гаргасан байна. Энд сургууль эцэг эх, олон нийтийн оролцоотой “Аюулгүйн зөвлөл” байгуулж сургуулийн гадна болон дотоод орчны тохижилт, аюулгүй байдалд эрсдэлийн үнэлгээг хийж, эрсдэл үүссэн тохиолдолд бууруулах арга хэмжээ авахаар заасан байдаг.

2018 онд БСШУСЯ-наас 131 сургуульд эрсдэлийн үнэлгээ хийхэд 21 хувь нь эрсдэл их, 80 хувь нь дунд, 30 хувь нь бага эрсдэлтэй гэсэн дүн гарсныг тус яамны дэд сайд Нийслэлийн ИТХ-ын 2018 оны 11 сарын 14-ны өдрийн хуралдаан дээр танилцуулсан байна. Эрсдэлийг бууруулах ажлыг зохион байгуулахаар БСШУСЯ, ИТХ хамтран ажиллахаар болсон нь манай төрийн байгууллагын уяалдаа холбоо сайжирч байгааг харуулж байна.

Гэхдээ ЕБС-ийн орчны аюулгүй байдлын стандарт урд өмнө нь манайд байгаагүй тул сургуулийн орчны эрсдэлийн үнэлгээг хийхэд баримтлах шалгуур шаардлагыг боловсронгуй болгон боловсруулах, аюулгүй орчныг бүрдүүлэх, байнгын хяналт үнэлгээ хийж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах зайлшгүй шаардлагатай байна.

Хүний Эрхийн Үндэсний Комисс, Гүүд Нэйборс Монгол төлөөлөгчийн газар хамтран хийсэн “Хүүхдийн эрх ба хамгаалал” сэдэвт КАР төрлийн буюу (КАР-knowledge, attitude, practice) мэдлэг, хандлага, хэрэглээг тодорхойлох судалгааг анх удаа үндэсний хэмжээнд хийсэн бөгөөд энэ судалгаагаар хүүхэд,

эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийн эрхийн талаарх мэдлэг ойлголт муутай, сум дүүрэг, баг хороонд хүүхэд хамгааллын хамтарсан баг байдаг гэдгийг ч сайн мэдэхгүй байна гэсэн дүгнэлт хийсэн байна.

ЮНЕСКО-оос 2019 онд сургуулийн орчин дахь дээрэнгүйлэл, дарангуйллыг зогсоох талаар судалгааны тайлан гаргасан байна. Уг тайланд Монгол Улсын хувьд сүүлийн 12 сарын хугацаанд сургуулийн орчин дахь дээрэнгүйлэл, хүчирхийлэлд өртсөн нийт хүүхдүүдийн 43.8 хувь нь зодоон хийсэн бол 30 хувь нь бие махбодын халдлагад өртсөн, сургуулийн орчинд дээрэлхүүлсэн, хүчирхийлэлд өртсөн сурагчдын ихэнх нь 14 настай хүүхдүүд байна гэж дурджээ.

2002-2017 оны хооронд хийгдсэн судалгаанаас харахад Монгол улсад 13-15 настай эмэгтэй хүүхдүүдийн дунд бие махбодийн халдлага, дээрэнгүйлэл нэмэгдсэн үзүүлэлт гарчээ. Манай улсад гарч буй сургуулийн орчин дахь дээрэнгүйлэл, хүчирхийллийн 22 хувь нь сэтгэл зүйн, 20.9 хувь нь бие махбодын, 3.3 хувь нь бэлгийн хүчирхийлэл байгаа бөгөөд эдгээр хүчирхийллийн 15.4 хувь нь сурагчдын гадна төрх, үзэмжээс, 3.4 хувь нь арьсны өнгө, үндэс угсаа, гарал үүслээс, 1.6 хувь нь шашин шүтлэгээс шалтгаалсан байна. Бие махбодын хүчирхийлэл хөвгүүдийн дунд илүү их тархалттай, сэтгэл зүйн хүчирхийлэл охидын дунд илүү их тархалттай байгаа үзүүлэлт гарчээ.

Энэ бүхнээс харахад сургуулийн орчинд хүүхдийн эрх хангагдахгүй, хүүхэд сэтгэл санааны болон бие махбодийн хүчирхийлэлд өртөж байгааг онцгой анхааран эцэг эх, сургууль, хүүхдийн хамтын ажиллагааг өргөжүүлж, хүүхдийг төлөвшүүлэх, бие хүн болгон хөгжүүлэхэд анхаарах шаардлагатай гэдэг нь харагдаж байна. Бид хэдийгээр эрх зүйт төртэй улс орон боловч хуулиа хэрэгжүүлэхгүй бол хүний эрх, тэр тусмаа өөрийгөө хамгаалах чадваргүй бага насны хүүхдүүдийн эрх өдөр бүр зөрчигдөж байгаа нь хуулийн хэрэгжилтийг ажил хэрэг болгох, хяналтын механизмыг сайжруулах, төрийн байгууллага, сургууль, эцэг эхийн уялдаа холбоог бэхжүүлэх нэн шаардлагатай байна гэдгийг илэрхийлж байна.

Гэхдээ хуулийг хэрэгжүүлэх хүрээнд БСШУСЯ, Японы хүүхдийг ивээх сантай хамтран эцэг эх, багштай харилцах дэвтрийг бага ангид хэрэглэхээр болсон. Харилцах дэвтэр нь эцэг эх, багш хоорондын харилцаа, хамтын ажиллагааг сайжруулах, хүүхдийн сургуульд дасан зохицох, суралцах чадварыг гэр бүлийн орчинд нь хөгжүүлэх талаар эцэг эхчүүдэд арга зүйн дэмжлэг

үзүүлэх зорилготой. Эцэг эхчүүд энэхүү дэвтрийг уншиж судлан зааврын дагуу тэмдэглэл хөтөлснөөр хүүхэдтэйгээ ажиллах арга зүй, аргачлалд суралцахаас гадна ангийн багштай санал бодлоо нээлттэй хуваалцаж хамтран ажиллах боломжтой болсон нь үр дүнтэй алхам болж байна.

Сургуулийн удирдлага, сургуулийн зөвлөлийн үйл ажиллагааны тухайд дараах эрх зүйн баримт бичгүүдээр зохицуулагдаж байна. Үүнд: Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2002 оны 230-р тушаалаар Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн зөвлөлийн үлгэрчилсэн дүрмийг баталсан байна. Энэ баримт бичигт зөвлөлийн зорилго, үйл ажиллагааны хэлбэрийн талаар дараах заалтууд бий.

1.2. Зөвлөлийн үндсэн зорилго нь сургууль, цэцэрлэгийн хөгжлийн бодлого, хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, сургууль, цэцэрлэгийн дотоод дэг журам, зохион байгуулалтын хэлбэрийг тодорхойлох, сургууль, цэцэрлэгийн болон тэдгээрийн захирал, эрхлэгчийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих, үнэлэлт, дүгнэлт өгөх, туслах, сургалтын ажлын чанар, түвшинг сайжруулах санал боловсруулах, багш, суралцагч, ажилтны эрх ашгийг хамгаалахад оршино.

2.4.1.Зөвлөлд орох багш, ажилтан, суралцагч, эцэг эхийн төлөөллийг тэдгээрийн хамт олны 50-аас доошгүй хувийн ирцтэй хурлаас тус тус сонгож тогтоол гаргана.

3.2.Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байх бөгөөд гишүүдийн 75 хувиас доошгүй ирцтэй хурлыг хүчинтэйд тооцно. Хурал хэлэлцсэн асуудал бүрээр олонхийн саналаар шийдвэр (тогтоол) гаргаж, тэмдэглэл хөтөлнө. Зөвлөлийн хурлын шийдвэр (тогтоол)-т дарга гарын үсэг зурж, тухайн сургууль, цэцэрлэгийн тамга (тэмдэг) дарж баталгаажуулна.

3.5.Зөвлөлийн хурлаар хэлэлцэж байгаа асуудлаар тухайн сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч, орлогч захирал, хичээлийн эрхлэгч (сургалтын менежер), багш, ажилтан, эцэг эх, суралцагчийн төлөөллийг хуралд оролцуулан тэдний санал, хүсэлт, тайлбарыг сонсож болно.

Бага, дунд боловсролын тухай хуулийн 19.1-д Ерөнхий боловсролын сургуулийн өөрийн удирдлага нь сургуулийн зөвлөл байна. Сургуулийн зөвлөл Боловсролын тухай хуулийн 35 дугаар зүйлд заасны дагуу байгуулагдан үйл ажиллагаагаа явуулна гэж заажээ.

Гэтэл бодит байдалд сургуулийн удирдлага, сургуулийн зөвлөлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд эцэг эхийн оролцоо сул, идэвхгүй, сургуулийн удирдлагын үйл ажиллагаанд зөвлөл байгуулаад хөндлөнгөөс хяналт тавих боломжтой гэдгийг ойлгохгүй, мэдэхгүй явдал байна. Эцэг эхийн энэхүү байдалд хүлээлгэх хууль эрх зүйн орчин одоогоор байхгүй байна. Энэ талаар боловсролын тухай хуульд болон холбогдох журмуудаар зохицуулах шаардлага гарч ирж байгаа юм.

Сургуулийн зөвлөлийн үйл ажиллагаанд нийт эцэг эхчүүд оролцоод өөрсдийн төлөөллөө гаргадаггүй болохоор сургуулийн удирдлага өөрийн танил талыг зөвлөлийн гишүүнээр сонгон хяналтгүй ажиллаж, эцэг эхийн зөвлөл гэсэн нэрээр үйл ажиллагаа нь тодорхойгүй, үр дүнгүй мөнгө хураан авах, ашиглах хандлага сүүлийн үед нилээд гарах болжээ. Боловсролын тухай болон нийтийн албаны тухай хуульд заагаагүй төлбөр авахыг хориглоно, хуулийг зөрчсөн тохиолдолд сахилгын шийтгэл ноогдуулна гэж заасан байдаг ч эцэг эхийн зөвлөл нэрийн дор авах тохиолдолд хариуцлага хүлээлгэх болон хориглох заалт байхгүй байна.

2001 онд Хүүхдийн эрхийн хорооны зөвлөмжийн дагуу НҮБ-ын Ерөнхий ассамблей 56\138 дугаар тогтоолын дагуу зөвлөх Пауло Сержио Пинхейро нарын дэлхийн хэмжээний хүүхдийн эсрэг хүчирхийллийн дүр зургийг тодорхойлох судалгаагаар хүүхдийн эсрэг хүчирхийлэл нь тухайн орны соёл, үндэстэн, ястны бүлэг, гэр бүлийн байдлаас үл хамааран дэлхийн бүх оронд түгээмэл илэрч байгааг тогтоожээ. Ихэнх хүмүүс хүүхэд эрхээ эдэлж, эрүүл саруул насанд хүрэгч болохын тулд хүчирхийллээс хамгаалагдсан байх ёстой гэдгийг мэддэг ч, ихэнх улс оронд хүчирхийлэл нь ёс заншил, ердийн үзэгдэл болон хүлээн зөвшөөрөгддөг байна. Энэхүү судалгаа нь хүүхдийн эсрэг хүчирхийлэл 5 төрлийн газар тохиолддог болохыг илрүүлсэн бөгөөд түүний нэг нь сургууль, боловсрол олгох бусад орчин болж байгааг илрүүлсэн байна.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэдэг нь гэмтэл бэртэл учруулах, зүй бусаар харьцах, анхаарч халамжлахгүй байх, үл хайхрах, бэлгийн хүчирхийлэл үйлдэх, мөлжих зэрэг бие махбод, сэтгэл санааны хүчирхийллийн бүх хэлбэрийг хэлнэ гэж “Хүүхдийн Эрхийн Конвенцийн 19 дүгээр зүйл”-д тодорхойлсон байна.


Хүүхдийн эсрэг хэн нэгэн этгээд биеийн болон материаллаг зүйлсийг ашиглах замаар хүч хэрэглэн, хүүхдийн бие махбодид ямар нэг хэмжээгээр халдах, бие махбодид хохирол амсаж болзошгүй нөхцөлд оруулах, эсвэл ийм

нөхцөлд орсныг мэдэж байвч хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй үйлдэл эс үйлдлийг бие махбодийн эсрэг хүчирхийлэл гэнэ. Өөрөөр хэлбэл, бие махбодийн эсрэг хүчирхийлэл гэдэгт дарамт, хүүхдийн бие эрхтэнд ямар нэгэн хохирол үзүүлэхээс гадна амь насанд нь халдах хүртэл үйлдэл, эс үйлдэл (Пинхейро, 2001) багтдаг.

Сэтгэл санааны дарамт нь хүүхдийн сэтгэл санааны хувьд амар амгалан, тайван байдлыг эвдэх ба хүүхдийг дорд үзэх, доромжлох, тохуурхах, нэр хоч өгөх, хараан загнах, айлгах, заналхийлэх, гадуурхах, ганцаардуулах, гүтгэх, үзэл бодлоо тулгах зэргээр илрэх үйлдэл, эс үйлдэл юм. Бусад хүчирхийллээс ялгаатай нь ихэнх нийгмүүдэд хүчирхийлэл дарамт гэж тооцохгүй байх явдал түгээмэл, мөн ийм төрлийн хүчирхийлэл дарамтыг илрүүлэх, тодорхойлох нь ихээхэн төвөгтэй [66.7] байдаг байна.

Үл хайхрах гэдэг нь асран халамжлах үүрэг хүлээсэн хэн нэгэн этгээд хүүхдийн суурь хэрэгцээг нь гачигдуулсны улмаас хүүхдэд гэм хор учруулсан, эсвэл учруулахаар завдсан, мөн тийм нөхцөл байдалд байгааг мэдсээр байвч хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй үйлдэл, эс үйлдлийг (Пинхейро, 2001) хэлнэ.

Монголд 2005 онд Английн хүүхдийг ивээх сан, Зохистой хөгжил Жендэр төвийн судлаачид хүүхдийн бие махбод, сэтгэл санааны эсрэг шийтгэлийг тодруулах судалгааг хийжээ. Уг судалгаа нь сургууль, цэцэрлэг, хорих анги, асрамж халамжийн төв гэсэн 4 салбарт хүүхэд бие махбод, сэтгэл санааны шийтгэлд хэр зэрэг өртөж байгааг болон шийтгэх, шийтгэхгүйгээр хүмүүжүүлэх бусад аргын талаарх хүүхэд, насанд хүрэгчдийн ойлголт, үзэл бодлыг судалсан байна. Уг судалгаанд зураг зурах, биеийн зураг, хандлагыг тандах, ярилцлагын аргуудыг ашиглан 595 хүүхдийг хамруулсан байна. Тэдгээр хүүхдүүдээс зөвхөн 12 нь л ямар нэгэн шийтгэлээр шийтгүүлж байгаагүй гэж хариулсан нь хүүхдийн бие махбод, сэтгэл санааны эсрэг шийтгэл хэр зэрэг өндөр түвшинд байгааг харуулсан юм. Мөн судалгаанд хамрагдсан 10-11, 14-15 насны хүүхдүүдийн 53,2 хувь нь сургуульд шийтгэл байнга тохиолддог хэмээн хариулсан нь хүүхдийг хүчирхийллээс хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэх ёстой сургууль нь эсрэгээр хүчирхийллийн орчин болж байгаа нь судлаачдын анхаарлыг татсан байдаг. Түүнчлэн хөдөөд судалгаанд хамрагдсан сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн 45,3 хувь нь зодуулдаг, 57 хувь нь хэл амаар доромжлуулдаг гэсэн дүн гарчээ.



Зураг 6. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн шийтгүүлсэн шалтгаан (хувиар)

Баримт бичгийн судалгааны үр дүнд Монгол дахь хүүхдийн эрхийн хэрэгжилтийн өнөөгийн байдалд тулгамдаж буй асуудлууд, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодрууллаа. Харин хууль, эрх зүйн орчин хувьд, Монгол улс нь хүний эрхийн үзэл баримтлал, олон улсын хэм хэмжээ, стандартыг үндэсний хууль эрх зүйн баримт бичгүүдэд тусгасан хэдий ч хүүхдийн эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах байдал төдийлөн хангалтгүй байна гэж хэлж болно. Хүүхдийн эрхийг хангах, хамгаалах ажил хангалтгүй байгаагийн хамгийн гол шалтгаан нь хууль, дүрэм журмыг мөрддөггүй, хариуцлага тооцох арга зам тодорхойгүй байгаатай холбоотой гэж үзэж болно.

Манай орны хувьд хүн бүр суурь боловсрол эзэмших эрх нь хангагдсан хэдий ч сургуулийн орчин хүчирхийллээс ангид байж чадахгүй байна. Хүүхдийн бие махбод сэтгэл санааны эсрэг шийтгэлийг боловсролын байгууллагын хүрээнд гаргахыг хориглосон зүйл, заалт боловсролын хуульд нэмэлт өөрчлөлтөөр орсон нь нэгэн амжилт боловч бодит байдал дээр хэрэгждэггүй, хүчирхийлэл бат бэх оршсоор л байна.

Хүүхдийг аливаа хүчирхийлэл, дарамтаас хамгаалах, урьдчилан сэргийлэх хууль эрх зүйн орчинг бий болгохын тулд амьдрал дээр хэрэгжих дүрэм журам, заавар зөвлөгөөг олон талын оролцоотойгоор боловсруулж хэрэгжүүлэхгүй байна. Хүүхдийн эрхийн зөрчил их, өргөн цар хүрээтэй байгаа нь манай орны хувьд хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон хүний эрхийн боловсролыг нийгмийн бүхий л бүлгүүдэд олгоход чиглэсэн бодлого, мэдээлэл сурталчилгааны үйл ажиллагаа зохион байгуулагдаагүй, иргэдийн дунд хүний эрхийн соёл хараахан төлөвшиж тогтоогүйтэй холбоотой юм.

Боловсролын хувьд авч үзвэл, аливаа боловсрол бол хүний эрхийн зөрчил, эрсдэлээс сэргийлэх, тэгш байдал, тогтвортой хөгжлийг дэмжих ёстой талаар өмнө нь бид тодорхой авч үзсэн. Ялангуяа, хүүхдийн эрхийн боловсрол бол нийгэм дэх шударга бус зүйлийн эсрэг тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх хэрэгсэл болохынхоо хувьд чөлөөт, ардчилсан, хариуцлагатай, шударга нийгмийг бүтээн байгуулах үндэс болдог. Ийм учраас хүний эрхийн боловсрол бол бүх хүн зайлшгүй хүртэх ёстой суурь боловсрол юм.

Манай орны хувьд хүүхдийн сургуульд хамрагдах байдал хэд хэдэн бүс нутагт нэмэгдэж байгаа боловч боловсролын чанар ихэнх тохиолдолд муу хэвээр байна. Тухайлбал, боловсролын талаарх сөрөг үзэл, хандлага, улс орны эдийн засгийн хөгжил, нийгмийн ялгаа, ядуурал болон эдийн засгийн чадавхигүй байдал, соёл уламжлалын зааг, жендерийн мэдрэмжгүй хөтөлбөр зэрэг нь сурч боловсрох эрхийг хэрэгжүүлэхэд саад тотгор болж байна. Хүүхдийн мэдлэг чадварт суурилсан, тэдний оролцоонд тулгуурласан суралцагч төвтэй сургалт зохион байгуулах ажил хангалтгүй байна. Удирдлага нь багшаа, багш нь удирдлагаа, багш нь суралцагчаа, суралцагч нь багшаа, суралцагч, суралцагчаа хүндэтгэх хүмүүнлэг харилцаа тогтож чадаагүй байна. Хичээлээс гадуур хүүхдийг хөгжүүлэх, хүмүүжүүлэхэд чиглэсэн олон хэлбэрийн ажлуудыг зохион байгуулах явдал багассан, нөгөө талаас одоогийн хүүхдүүдийн идэвх сонирхол буурсан. Энэ нь эцэг эх, багш нарын хараа хяналт буурсан, хүүхдийн сонирхол татахуйц олон шинэ зүйл бий болсонтой холбоотой. Жишээ нь, интернет, тоглоомын газар, мэдээлэл авах олон суваг бий болсон гэх мэт.

Хүүхдийг хөгжүүлэх, хүмүүжүүлэх ажилд хөрөнгө төсөв, материаллаг нөөц дутагдаж байна. Сургууль хүүхдийн сэтгэл татахуйц таатай орчин нөхцөлийг бүрдүүлж чадахгүй байна. Сургууль дээр багш болон бусад суралцагчдын зүгээс хүчирхийлэх явдал гардаг. Сургуулийн орчны хувьд, хүүхдийг хүчирхийллээс ангид байлгах таатай орчин болж чадаагүй хэвээр байна. Сургуулийн орчинд ямар ч хамгаалалт байхгүй, сургуулийн дотуур байр хүүхдийн хүчирхийлэл дарамтаас хамгаалагдаж чадаагүй, сургуулийн удирдлага, багш нар суралцагчдын саналыг сонсдоггүй, шууд дагахыг шаарддаг, суралцагчдыг доромжлох, ялгаварлалтай тэгш бус харилцаатай, санал бодлоо нээлттэй, чөлөөтэй илэрхийлэх боломжгүй, хамтын ажиллагаагүй, захиргаадсан шинжтэй, сургуулийн шийдвэр гаргах үйл


ажиллагаанд оролцох боломжгүй, хаалттай (багш нар нь оролцох боломжгүй), сургуулийн удирдлага дангаар шийдвэр гаргаж түүнийгээ сохроор дагаж мөрдөхийг шаарддаг, сургуулийн дүрмийг боловсруулахад суралцагч оролцох боломжгүй, сургуулийн материаллаг бааз хангалтгүй, сурах бичиг техникийн хангамжгүй муу байгаа зэрэг тулгамдсан асуудлууд байсаар байна. Хүүхдийн сурч боловсрох эрхийг хангахад боловсролын салбарт хөрөнгө, төсөв, материаллаг нөөц дутагдаж байна. Мянганы хөгжлийн зорилтын тухай илтгэлд Монгол улс хүний эрхийн холбогдолтой гэрээ, конвенцуудыг баталсан хэдий ч эдгээр эрхийг бүрэн хэмжээгээр хэрэгжүүлэх засгийн газрын хөрөнгө хомс, чадавх муу байна гэж тодорхойлжээ. Энэ байдал нь хүүхдийн үндсэн эрх болох сурч боловсрох эрх хангагдахгүй байх гол хүчин зүйл болж байна.

Боловсролоор амьдралд хэрэгцээгүй, хэт их хийсвэр онолын мэдлэг олгодог уламжлал байсаар байна. Багш боловсролд сургалтын орчин үеийн арга зүйн хэрэглээ дутагдаж байна. Багш суралцагчдын сургалтын уламжлалт арга барил зонхилж, хүүхдийн сурах сонирхлыг бууруулж, суралцагчдыг хичээл сургалтад хандах хандлагад нөлөөлж байна. Үүнтэй холбоотойгоор суралцагчдыг хичээл, сургалтад анхаарлаа хандуулах, сурлагын амжилтыг нь нэмэгдүүлэх үүднээс айлгасан, сүрдүүлсэн, хүч хэрэглэсэн, албадлагын шийтгэлийг хэрэглэж байна.

Боловсролд иймэрхүү өнгө төрөх зонхилохыг ХХ зууны эхэн үед Дж.Дьюн “Ширээнийхээ ард цэх томоотой суух сурагчидгүйгээр багш сургалтыг төсөөлөхөө больсон” гэж бичиж байсан бол ХХ-р зууны төгсгөлд М.Липман “Багшийн заасныг залгих мэт суух сурагчид” гэж зураглаж [67.99] байв.

Хичээлийн хөтөлбөр боловсруулах хязгаарлагдмал байдал бас нөлөөтэй юм. Тухайлбал, хүүхэд төвтэй, хүүхдийн хэрэгцээ сонирхолд тулгуурлаагүй, хүүхдийг идэвхтэйгээр суралцах явдлыг дэмжээгүй, хүүхдийн эрхийг хангах, хамгаалахад чиглэгдээгүй, жендерийн мэдрэмжгүй хичээлийн хөтөлбөр, хичээлийн хөтөлбөрийн стандартчлагдсан (энэ нь нэг загвартай, өөрчлөгддөггүй), хүүхдийн мэдлэг, чадварт суурилсан бус байдал нь хүүхдийн эрхэд суурилсан боловсрол олгоход саад тотгор болж байна.

1.Сургуулийн барилга байгууламж: багтаамж ба чанар. (Бүдүүвч 1.3-аас үзнэ үү).



Бүдүүвч 1.3. Сургуулийн барилгуудын анх баригдахад төлөвлөгдсөн сурагчдын тоо ба одоогийн сурагчдын тооны харьцаа

Засгийн газрын зорилтуудад сургуулийн барилга байшин шинээр нэмж барих асуудал ямагт тусгагдан, шинээр барих, өргөтгөх үйл явц жил бүр явагдаж байгаа боловч энэ нь хөгжлийн болоод нийгмийн суурь өөрчлөлтийн хурдыг гүйцэхгүй байгаа нь судалгаанаас харагдаж байв. Мөн ихэнх сургуулиуд орчны аюулгүй байдлын асуудлыг зөвхөн сургуулийнхаа хашаагаар хязгаарлан үздэг нь ч судалгаанаас харагдаж байна.

Сургуулийн орчин	Тийм	Үгүй
Спортын ба тоглоомын талбай аюулгүй	80%	20%
Хурдны хязгаарлалт, гарцны тэмдэглэгээтэй	21.7%	78.3%
Орчны гэрэлтүүлэгтэй	61.7%	38.3%
Сургуулийн хашаа бүрэн бүтэн	81.7%	18.3%

Хүснэгт 2. Сургуулийн орчны аюулгүй байдал (Асуулга, n=500)

Тухайлбал, судалгаанд хамрагдсан 5 сургууль тутмаас 4 нь сургуулийн хашааны гаднах зам дээр хурдны хязгаарлалт ба гарцны тэмдэглэгээгүй байгаа нь хүүхдийн аюулгүй орчинд сурч боловсрох эрхэд хайхрамжгүй хандаж байгаагийн илрэл гэж хэлж болно. Судалгаанд хамрагдсан нийт сургуулийн хувьд спортын ба тоглоомын талбайн аюулгүй байдал харьцангуй сайн хангагдсан байгаа боловч, ялангуяа Улаанбаатар хотоос судалгаанд хамрагдсан сургуулиудын хувьд энэ нь бэрхшээлтэй асуудал болохыг сургуулиудын 60 шахам хувь нь тэмдэглэсэн байв. (Хүснэгт 1.5-аас үзнэ үү).

2. Анги танхимын хүрэлцээ, хүртээмжтэй байдал.

Нэг сурагчид ноогдох хичээллэх анги танхимын хэмжээг судалгаанд хамрагдсан сургуулиудын хувьд авч үзвэл 43.9 хувь нь 1 м², 38.6% нь 2 м², 7% нь 3 м², харин үлдсэн 10.5 хувь нь 4 ба түүнээс дээш м² талбай ноогдохоор багтаамжтай байгаа ажээ. Үүнийг хот, хөдөөгийн ялгаагаар нь харуулав. (Хүснэгт 1.6-аас харна уу).

	1 м.кв	2 м.кв	3 м.кв	4-17 м.кв	Нийт хувь
Улаанбаатар	71.4%	28.6%	.0%	.0%	100.0%
Аймгийн төв	60.0%	10.0%	10.0%	20.0%	100.0%
Сумын төв	35.0%	47.5%	7.5%	10.0%	100.0%

Хүснэгт 3. Нэг сурагчид ноогдох анги танхимын талбай (Захирлын асуулга)

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль 2016 оны 2-р сарын 05-нд батлагдсан. Тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжих эрхийг хангах, тэдний онцлог байдлыг хүндэтгэх талаар заасан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрхийг хангахад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багшийн хүрэлцээ дутмаг, сургалтын хөтөлбөр ердийн сургуульд суралцах нөхцөлд нийцэхгүй байх, сургалтын үнэлгээний аргачлал гараагүй, сургуулийн орчин, түүний тохижилт тэдний онцлог хэрэгцээнд тохирохгүй байдал зэрэг хүчин зүйлс сөрөг нөлөө үзүүлж байна.

2010 онд Монгол Улсын Засгийн Газрын 31 тоот тушаалаар батлагдсан "Боловсрол" үндэсний хөтөлбөрт "Сургууль, цэцэрлэгийн суудлын тоо хүрэлцээгүйн улмаас анги дүүргэлт тогтоосон нормативаас давж, сургалтын орчны наад захын шаардлага зөрчигдөн, багш сурагчийн үйл ажиллагааг хүндрүүлж, боловсролын чанар, сургалтын арга зүйн шинэчлэлд сөрөг нөлөө үзүүлж байна. Сургуулиудын 76 хувь нь хүчин чадлаасаа 1.8-2.0, цэцэрлэгүүдийн 80% нь хүчин чадлаасаа 1.5-2.0 дахин их ачаалалтай ажиллаж байна гэсэн дүгнэлт хийгдсэн байдаг.


ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ХОТЫН ИНДЕКС ТОГТООХ СУДАЛГАА

Гурав. Хүүхдэд ээлтэй хотын индексийн олон улсын туршлага

Хүүхдэд ээлтэй хотын тухай ойлголт нь НҮБ-ийн 1992 оны хүүхдийн эрхийн конвенцоос эх үндэстэй (UNICEF, 1992). 1996 онд Туркийн Истанбулд “Хүүхдэд ээлтэй хотууд” санаачлага анх эхэлсэн байдаг. Дэлхийн улс орнууд хүүхдэд ээлтэй хот, орон нутгийг бий болгох санаачлагыг сүүлийн жилүүдэд идэвхтэй дэмжиж байна. Ялангуяа буурай хөгжилтэй болон хөгжиж орнуудын хотын өмнө хүүхдийн эрх, аюулгүй байдал, орчинтой холбоотой өргөн хүрээтэй олон асуудлууд тулгамдаж байна.

Хүүхдэд ээлтэй хотын талаарх үзэл баримтлалын ойлгохын тулд онолын түвшинд харах ёстой. Онолын суурь нь бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаандаа өөрчлөлт хийснээр хүүхдийн амьдралд өөрчлөлт гарна гэсэн онолын үзэл дээр тулгуурладаг.

Зураг 7 Хүүхдэд ээлтэй хот: Өөрчлөлтийн онол



Эх сурвалж: (UNICEF. United Kingdom, 2017)

Хүүхдэд ээлтэй хотын санаачлага нь хүүхдийн эрхийн конвенцийн хэрэгжилттэй шууд холбоотой. Хүүхдэд ээлтэй хотын үзэл баримтлал нь үндсэн дөрвөн зарчим дээр тулгуурладаг. Энэ нь алагчлалгүй хандах, дээд ашиг

сонирхлыг харгалзах, амьдрах, хөгжих дээд бололцоог хангах, хүүхдийг сонсож, үзэл бодлын хүндэтгэх явдал юм. Тухайн хот хүүхдэд ээлтэй хот болохын тулд хүүхэд бүрт дараах эрхийг хангаж өгсөн байх ёстой.

1. Хотынхоо шийдвэрт нөлөөлдөг байх
2. Хотоо ямар байлгахыг хүсэж байгаагаа илэрхийлдэг байх
3. Гэр бүл, олон нийт, нийгмийн амьдралд оролцох
4. Эрүүл мэнд, боловсрол, орон байраар хангагдах зэрэг үндсэн үйлчилгээг авдаг байх
5. Аюулгүй цэвэр ус ууж, ариун цэврийн байгууламжаар хангагдах
6. Мөлжлөг, хүчирхийлэл, дарамт шахалтаас хамгаалагдсан байх
7. Гудамжинд ганцаараа аюулгүй алхах
8. Найзуудтайгаа уулзаж, тоглох
9. Ургамал, амьтанд зориулсан ногоон орчинтой байх
10. Бохирдолгүй орчинд амьдрах
11. Нийгэм, соёлын үйл ажиллагаанд оролцох
12. Өөрийн хотын эрх тэгш иргэн байх
13. Үндэс угсаа, шашин шүтлэг, орлого, хүйс, хөгжлийн бэрхшээл, гарал үүсэл харгалзахгүйгээр үйлчилгээ авах багтана.

Эдгээрийг хангаж чадсанаар хүүхдэд ээлтэй хотын алсын хараа гарч ирнэ. Хамгийн гол нь хүүхдийн эрхийг хүлээн зөвшөөрч, түүнийг хэрэгжүүлэхэд бодлого, төлөвлөлтөө чиглүүлэх ёстой. Хүүхдэд ээлтэй хотын үзэл баримтлалыг орон нутгийн түвшинд буулгах ёстой бөгөөд үүнд 9 үндсэн хүчин зүйл чухал үүрэгтэй. Нэгдүгээрт, хүүхдийн оролцоог хангаж, тэдний дуу хоолойг сонсож, шийдвэр гаргах үйл явцад оруулах, хоёрдугаарт, хүүхдэд ээлтэй эрх зүйн орчинг бүрдүүлж, эрхийг хангаж, хамгаалах, гуравдугаарт, хотын хэмжээнд хэрэгжих хүүхдийн эрхийн стратегийг хэрэгжүүлэх, дөрөвдүгээрт, хүүхдийн эрхийг хангах нэгж байгуулах, түүнийг удирдан чиглүүлэх, тавдугаарт, хүүхдэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг хийж, бодлогын хэрэгжилтийн үр нөлөөг тооцох, зургаадугаарт, хүүхдийн төсвийг нэмэгдүүлэх, долоодугаарт, хотын хүүхдийн нөхцөл байдлын тайланг тогтмол гаргаж, шаардлагатай мэдээ баримтуудыг цуглуулдаг байх, наймдугаарт, насанд хүрэгчдэд хүүхдийн эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг хүргэн, таниулах, есдүгээрт, хүүхдийг хамгаалах бие даасан өмгөөллийг дэмжиж ажиллах чухал үүрэгтэй (UNICEF, 2015).

Хот бүрийн өмнө тулгамдсан олон асуудлууд байдаг. Тэдгээрийн дундаас хүүхдийн асуудлыг яагаад онцлох ёстой вэ ?

- Хүүхэд нь бие даасан хүн юм. Тэдэнд насанд хүрэгчидтэй адил эрх бий, тэд бол эцэг эхийн эзэмшилд байдаг өмч, улсын бүтээгдэхүүн биш юм.
- Хүүхдийн эрүүл хөгжил, идэвхтэй оролцоо нь хот, өргөн утгаараа нийгмийн ирээдүйн хөгжилд чухал үүрэгтэй
- Хүүхэд нь бүрэн хамааралтайгаар бидний дунд хөл тавьдаг. Тэд насанд хүрэгчдийн тусламжтайгаар өсөж хөгжинө.

- Тэдний хамаарал, хөгжлийн явц нь хүүхдийг улам эмзэг, мэдрэмтгий болгодог. Өөрөөр хэлбэл, орлогын түвшин, орон байрны нөхцөл, байгаль орчны бохирдол нь шууд нөлөө үзүүлнэ.
- Хүүхдүүд үйлдэл, эс үйлдлээс хамаарч янз бүрийн нөлөөнд ордог. Төрийн бодлого бүхэлдээ хүүхдэд шууд болон шууд бусаар нөлөө үзүүлж байдаг. Хүүхэд нь нийгэм, хүрээлэн буй орчин, эдийн засгийн өөрчлөлтийн туйлын мэдрэмтгий барометр болдог.
- Хэрвээ хүүхдэд анхнаас нь анхаарал хандуулахгүй орхивол эргээд ирээдүйд асар өндөр зардлыг бид гаргах шаардлага үүснэ. Хүүхдийг эхийн хэвлийд бүрэлдэхээс өмнө тэдний өсөлт, хөгжилтөд нөлөөлөх эерэг, сөрөг хүчин зүйлсийг тооцож, төрийн бодлогын түвшинд анхаарах шаардлагатай.

Судалгааны энэхүү хэсэгт хүүхдэд ээлтэй хотын олон улсын туршлагын тухай авч үзнэ.

АНУ-ын туршлага, сургамж

Америкийн хотын хүн амын 25 орчим хувийг хүүхдүүд эзэлдэг бөгөөд 1960 – аад оноос эхлэн хотод амьдарч буй хүүхдийн нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг судлаж эхэлсэн байна. Тухайлбал “Америкийн хотууд дах амьдралын хэв маяг, нас баралт” бүтээлд цэцэрлэгт хүрээлэн болон засмал зам дагуух гудамж талбайн орчин дах хүүхдийн үйл ажиллагааны харьцуулсан судалгааг хийсэн байдаг (Jane Jacobs, 1961). Энэ мэтчилэн хотын орчин дах хүүхдийн асуудлаар суурь судалгаанууд тасралтгүй хийгдсээр ирсэн байна.

1990-ээд оноос судлаачид хүүхдийн асуудлыг аюулгүй байдал болон амьдарч орчиндоо ая тухтай, таатай амьдрахтай холбож судлах тал дээр анхаарах болжээ. Дэлхийн II дайны дараа Америкын хотууд хурдны зам, хязгаарлагдмал ил задгай талбайтайгаар төлөвлөж ирсэн бол сүүлийн үед хүүхдийн амьдарч буй орчинд замын хөдөлгөөнийг хязгаарлаж бууруулах чиглэлд явж байгааг судалгаануудад тэмдэглэх болжээ. Хотод нас барж буй хүүхдийн 20 хувь нь замын хөдөлгөөний ослоор эндэж байгаа нь анхаарах асуудал болсныг судлаачид онцлох болжээ (Newman, 2016)

XX зуун гарснаар хотжих үйл явцад өөрчлөлтүүд орж биеийн хүчний хөдөлгөөн багассан нь Америкын хотууд түгээмэл болсон байна. Үүний шалтгаан нь хүүхдүүдэд цугларч, нэгдэх талбай цөөрсөн, цэцэрлэгт хүрээлэнгүүд гэрээс нь хол зайтай, гудамж талбай өмнөх үетэй харьцуулахад илүү аюултай болсон, эцэг эхчүүдийн хандлага өөрчлөгдөж үр хүүхддээ тавих анхаарал нэмэгдэн гадуур тоглуулах сонирхол багассан, хүүхдийн ухаалаг утас, компьютер, зурагт, цахим тоглоомын хэрэглээ нэмэгдсэнтэй холбоотой юм. Энэ байдал Ковид-19 цар тахлын нөлөөгөөр улам бүр нэмэгдсэн байна.

Судлаачид хүүхдүүд ямар нэг хязгаарлалт багатай орчинд тухайлбал явган хүний зам, худалдааны том төвүүд, эсвэл нуугдах, янз бүрийн дүрд орон

төсөөллийн орчинг бүрдүүлэх боломжтой цас, ус, элс ихтэй газруудад тоглох сонирхол ихтэй байдгийг илрүүлсэн байдаг (Egli V, 2020). Энэ мэтчилэн судалгааны үр дүн дээр тулгуурласан хот төлөвлөлт, хүүхдэд ээлтэй орчинг бүрдүүлэх чиглэлд Америкийн хотууд анхаарч байна. Өөрөөр хэлбэл судалгаа, шинжилгээ, нотолгоон дээр тулгуурлан бодлого боловсруулж, төлөвлөх, шийдвэр гаргах үйл явц явагдаж байна.

Олон хотод хүүхдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн орчин, нөхцөлийг бүрдүүлэх чиглэлд бодлого боловсруулсан байна. 2020 онд UNICEF – ийн дэмжлэгтэй хүүхдэд ээлтэй хотын загвар төлөвлөгөө хэрэгжиж эхэлжээ. Энэ хүрээнд Хьюстон, Миннеполис, Сан-Франциско хотуудад туршилт хөтөлбөр эхэлсэн байна.

Хүүхдэд ээлтэй орчинг бүрдүүлэхэд амьдарч буй орчин тойрон хамгийн чухал юм. Энэ хүрээнд **15 минутын хот** гэсэн зарчмыг нэвтрүүлсэн. Энэ нь өдөр тутмын бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг гэрээсээ 10-15 минут алхаад авах боломжийг бүрдүүлэх тухай юм. Учир нь амьдарч буй орчин нь хүүхдийн хөгжилд чухал нөлөө үзүүлдэг. Энэ хүрээнд тодорхой хэмжилтийн аргачлалыг 6-14 насны хүүхдэд зориулан боловсруулсан байна. 6 хүртлэх насны хүүхэд нь эцэг эхээс шууд хамааралтай байдаг учраас аргачлалд оруулаагүй байна. Харин 6-14 насны хүүхэд нь илүү бие дааж шийдвэр гаргадаг, орчин тойроноо судлах, бусадтай харилцаанд орох, бие даан эрэл хайгуул хийж явдаг (U.S. Census Bureau, 2019).

Хүүхдийн амьдарч буй орчны үнэлгээг 6 бүлэг 23 шалгуур үзүүлэлттэйгээр боловсруулсан байна. Үүнд:

1. Гэрийн орчин нөхцөл
2. Эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ
3. Боловсролын үйлчилгээ
4. Аюулгүй байдал, хамгаалал, тээвэр
5. Тоглох, амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх
6. Нийгмийн амьдрал орно.

Дээрх шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээг хийхэд тодорхой асуудлууд үүссэн байдаг. Тухайлбал эцэг эх болон хүүхдээс мэдээлэл цуглуулах нь цаг хугацаа их зарцуулдаг. Зарим шалгуур үзүүлэлт нь хот төлөвлөлтийн бодлого, зорилготой шууд холбогддоггүй байна. Тиймээс дээрх хүндрэлийг бууруулахын тулд захиргааны мэдээллийг ашиглах замаар цаг хугацаа, зардлыг бууруулах, асуулгын тоог зөвхөн Америкийн хотууд хамааралтайг сонгох зэргээр өөрчилсөн туршлага байна.


Америкийн жишээн дээр хүүхдэд ээлтэй хотыг дараах байдлаар үнэлэж байна. Үүнд:

1. 18-24 оноо: Хүүхдэд ээлтэй орчинтой
2. 12-18 оноо: Хүүхдэд зарим талаар ээлтэй орчинтой

3. 6-12 оноо: Хүүхдэд ээлгүй орчинтой
4. 0-6 оноо: Хүүхдэд тохиромжгүй орчинтой

Эндээс хүүхдэд ээлтэй хотын индексийг гаргаж ирсэн байдаг. Судалгааны нийт үр дүнг жишээгээр харвал дараах байдал харагдаж байна. Зураг 1 дээрээс харвал судалгаанд хамрагдсан 4 дүүргийн тухайд 3 нь хүүхдэд зарим талаар ээлтэй, 1 дүүрэг ээлгүй орчинтой гэсэн ангилалд багтаж байна. 6 бүлэг шалгуур үзүүлэлтээр харвал хот бүр харилцан адилгүй байна. Энэхүү судалгаанаас гарсан нэг сонирхолтой дүгнэлт нь орлогын хувьд бага орлогтой орчин нь хүүхдэд ээлтэй болон ээлгүй хоёрын дунд, орлогын түвшин дундажаас дээгүүрт ордог дүүргийн хувьд хүүхдэд ээлгүй ангилалд багтсан байна. Эндээс орлого нь хүүхдэд ээлтэй эсэхийг шийдвэрлэхэд хүчтэй нөлөө үзүүлдэггүй гэдэг нь харагдаж байна.

Зураг 8. Шалгуур үзүүлэлтийн индексийн үр дүн



Эх сурвалж: (Nelya Rakhimova, 2022)

Дээрх аргачлалаар туршилт судалгаа хийсний дараа асуулгыг сайжруулан дараах шалгуур үзүүлэлтийг боловсруулсан байна. Хүснэгт 1 дээрх шинэчилсэн аргачлалын суурь үзэл баримтлал нь Вулькок болон Стийл нарын

үзэл дээр тулгуурласан (Woolcock, Geoff, and Wendy Steele., 2008). Тэдний үзлээр хүүхдэд ээлтэй хот нь дараах шинжүүдийг агуулсан байна. Үүнд:

1. Хүүхдийн сонгох эрх
2. Хүүхдийн аюулгүй байдал, хамгаалал
3. Хүүхдийг хүндэлж, үнэ цэнийг хүлээн зөвшөөрөх
4. Хүүхдийн эрүүл мэнд
5. Бие даан зорчих
6. Олон төрлийн үйчилгээ авч үйл ажиллагаанд оролцох
7. Хамт олны харьяалал, холбоотой байх мэдрэмж
8. Бодит оролцоо ба бие даасан байдал
9. Тоглох замаар танин мэдэх боломж
10. Байгаль орчин, ногоон байгууламжтай холбогдох багтана.

Энэхүү үзэл баримтлал дээр тулгуурлан 1. Орон байрны орчин, 2. Эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ, 3. Боловсролын нөөц, 4. Аюулгүй байдал ба хамгаалал, 5. Хөдөлгөөн, 6. Тоглох, чөлөөт цагаа өнгөрүүлэх боломж, 7. Хамтын амьдралд оролцох гэсэн 7 үндсэн хэмжигдэхүүнийг гаргаж ирсэн байна.

Хүснэгт 1. Хүүхдэд ээлтэй орчинг хэмжих үнэлгээний хэрэгсэл

Evaluation Dimension	Indicator
Home Environment	1. Space available at home (e.g. <1 person per room, or <2 people per bedroom) 2. Families have access to affordable housing 3. Families have access to safe and secure housing 4. Access to outdoor space (e.g. yard, patio, balcony, shared courtyard, pocket park, etc.) 5. Air quality and/or water quality
Health and Social Services	6. Distance to urgent care, ER, hospital 7. Emergency response times 8. Obesity rates and/or asthma rates 9. Youth mental health services 10. Healthy food access: distance to grocery store, market, farmer's market
Educational Resources	11. Distance to primary school 12. Distance to middle school (accessible by walking, bike, or transit) 13. Distance to child day care and after school services 14. Distance to additional educational services (e.g. libraries) (accessible by walking, bike, or transit)
Safety and Protection	15. Overall crime rate 16. Child-related crime rate 17. Incidence of traffic accidents 18. Block watch program
Mobility	19. Street speed limits 20. Distance to bus stops/transit 21. Number and quality of bicycle lanes (protected versus unprotected) 22. Number and quality of sidewalks 23. Safe routes to school program/walking school bus
Access to Play and Recreation	24. Distance to parks 25. Distance to playgrounds 26. Distance to sports facilities 27. Distance to public swimming pools 28. Distance to community recreation centers 29. Distance to big parks with nature areas, trails, rivers, and/or lakes 30. Presence of play streets programs
Community Life	31. Board meetings and community meetings 32. Diversity (racial and/or age diversity) 33. Education attainment: Percentage of educated people 34. Presence of after school programs, library events, recreation center programming 35. Including children in public participation and decision making

Эх сурвалж: (Nelya Rakhimova, 2022)

Америкийн хүүхдэд ээлтэй хотыг бий болгох, түүнийг хэмжих шалгуурын тухайд олон жилийн суурь судалгаа болон, UNICEF-ийн дэмжлэг, арга зүйтэйгээр өөрийн улсын онцлогт тохирсон арга зүй, аргачлалыг боловсруулсан байна. Үүний тулд нэгдүгээрт, сонгогдсон хотод туршилт судалгаа явуулж, түүний үр дүнд тулгуурлан, арга зүйгээ улам сайжруулж байна.

Беларус улсын туршлага

Беларус улсын тухайд хүүхдэд ээлтэй хот санаачлагыг нийт 25 хотод хэрэгжүүлж, үнэлгээг хийсэн. Тус улсын хотууд нийтлэг тулгамдаж байгаа асуудал нь орчны бохирдол, хүүхдийн тоглоомын талбай дутмаг, замын хөдөлгөөн ихтэй, зам тээврийн ослын эрсдэл өндөр, стрессийн түвшин их, хууль бус үйл ажиллагаа, мансууруулах бодисын хэрэглээний асуудал багтана.

Беларусын тухайд 6-12 насны хүүхэд, 13-17 насны өсвөр үеийнхэн, 0-12 настай хүүхэдтэй эцэг эхүүдээс нийслэл хот, муж, дүүргийн түвшинд хийсэн. Хүүхдэд ээлтэй хотын индексийн судалгаа нь 7 параметр, 41 үзүүлэлттэй хийгдсэн байна. Индексүүдийг 0-10 хүртлэх хэмжүүрт шилжүүлж, 10 нь хамгийн сайн, 0 нь хамгийн муу гэсэн утгыг агуулахаар төлөвлөсөн байна. Долоон параметрт

1. Хүүхдийн нийгмийн амьдрал, шийдвэр гаргах үйл явц дах оролцоо
2. Амьдрах орчин
3. Хотод амьдарч буй хүүхдийн аюулгүй байдал
4. Эрүүл мэндийн үйлчилгээ болон эрүүл амьдралын хэв маяг
5. Боловсрол ба хөгжил
6. Амралт, соёл
7. Хэцүү хүнд нөхцөлд туслах байдал багтсан.

2012 онд тус судалгааг эхлэх үед хотуудын дундаж индекс 6.9 байсан бол 2017 онд таван жилийн дараа 7.7 болж нэмэгдсэн байна. UNICEF – ээс Минск хотыг хүүхдэд ээлтэй хотоор тодруулсан байдаг.

Зураг 9. Хүүхдэд ээлтэй хот Минск



Беларусын жишээн дээр хүүхдэд ээлтэй хотын индекс тодорхойлох ажил нь нэгдүгээрт, индексийг тооцох, хоёрдугаарт, хотод амьдарч буй хүүхэд, насанд хүрэгчдийн нөхцөл байдалтай холбоотой тайланг бэлтгэх, гуравдугаарт, хотын хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг хүүхдэд ээлтэй хотын индексийн үндэс дээр тулгуурлаж боловсруулах, шинэчлэх, дөрөвдүгээрт, дахин нөхцөл байдлын тайлан бэлтгэх, тавдугаарт, хотын хөгжлийн төлөвлөгөө хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах гэсэн үе шаттайгаар хэрэгжсэн байна.

Беларусын жишээн дээр нэг онцлог нь хэд хэдэн хотыг нэг үзүүлэлтээр харьцуулж гаргах аль эсвэл нэг хотыг олон үзүүлэлтээр гаргах байдлаар тайланг өөр өөр загвараар боловсруулсан байна.

Их Британи улсын туршлага

Их Британи улсын хувьд 2013-2016 онд сонгогдсон таван хотод туршилт хөтөлбөр “Хүүхдийн эрхийн түншүүд”-ийг хэрэгжүүлсэн бөгөөд 2016-2017 онд Белфастын хатан хааны их сургууль дээр түшиглэж хөтөлбөрийн үнэлгээг хийсэн байна. Улмаар 2017 онд “Хүүхдэд ээлтэй хот болон хүй нэгдлүүд” гэсэн санаачлага өргөжиж хэрэгжсэн байна. 2018-2020 онд 30 гаруй хотыг хамарч өргөжсэн байна.

Тус улсын хувьд хүүхдэд ээлтэй хотын хүрээнд

- Хүүхдэд нөлөөлөх шийдврийн талаар саналаа хэлэх
- Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх урам зоригийн дэмждэг байх
- Эрүүл мэнд, боловсрол, тээвэр болон бусад үйлчилгээг авах
- Аюулгүй байдлаа мэдэрч, ялгаварлан гадуурхалт, хор хөнөөлөөс хамгаалагдсан байх
- Олон нийтийн газар зугаалж, бусад хүүхдүүдтэй чөлөөтэй уулздаг нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарсан байна.

Тус хөтөлбөр хэрэгжихээс өмнө нөхцөл байдлын шинжилгээг хийхэд гол хүчин чармайлтыг гаргасан байна. Энэ хүрээнд суурь нөхцөлөө тодорхойлох судалгаа хийх, фокус групп ярилцлага явуулах, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, үйл ажиллаганы төлөвлөгөөг эргэн харж сайжруулах байдлаар эхэлсэн байдаг.

Стратеги төлөвлөгөө дагаж гарсан байна. Стратеги гарахаас өмнө хүүхдийн үйлчилгээний хамтын ажиллагааны тухай хууль 2015 онд батлагдаж, түүний дагаж “Хүүхэд болон залуучуудын 2017-2027 оны стратеги төлөвлөгөө” боловсруулагджээ.

Тус санаачлага бүхэлдээ амжилттай хэрэгжихэд UNICEF -ийн үүрэг оролцоо өндөр байсан. “Хүүхдийн эрхийн линз” үйл ажиллагааны хэрэгжүүлэх

хүрээг тодорхойлж өгсний дараа хүүхдийн эрхийн үндсэн дээр тулгуурласан алсын харааг боловсруулахад тусласан байдаг.

UNICEF-ийн зүгээс тасралтгүй дэмжлэг, зөвлөмж хүргэж, оролцогч талуудыг амжилтад хүрэхэд, орон нутгийн хүний нөөцийг чадавхжуулах ажлыг хийсэн байна.

Казахстан улсын туршлага

1996 онд

Казахстан улсын тухайд тус санаачлагад нэгдэх ажил нөхцөл байдлын судалгааг захиргааны статистик мэдээлэл болон нас насны хүүхдүүдийг судлахаас эхэлсэн байна. Хүүхдэд ээлтэй хот байна гэдэг нь хүүхэд бүрт дараах эрхийг хангах явдал юм. Үүнд:

- Хотынхоо талаар санал бодлоо илэрхийлэх
- Хотынхоо шийдвэрт нөлөөлөх
- Гэр бүл, нийгмийн амьдралд оролцох
- Эрүүл мэнд, боловсрол, орон байр зэрэг суурь үйлчилгээг авах
- Цэвэр ус ууж, эрүүл ахуйн шаардлага хангасан орчинд амьдрах
- Мөлжлөг, хүчирхийлэл, дарамт шахалтаас хамгаалагдах
- Ногоон орчинд амьтан, ургамалтай ойр байх
- Бие даан гудамж талбайгаар аюулгүй алхах
- Найз нөхөдтэйгээ уулзаж тоглох
- Бохирдолгүй орчинд амьдрах
- Соёл, олон нийтийн арга хэмжээнд оролцох
- Хотын тэгш эрхтэй иргэн байж, арьс өнгө, угсаа гарал, шашин, орлого, жендэр, хөгжлийн бэрхшээлээс үл хамааран бүх үйлчилгээг хүртэх асуудал багтана.

Хүүхдэд ээлтэй хотын санаачлага эхэлсний дараа Казахстаны Сатпаев, Саран, Семей, Уст-Каменогорск зэрэг хотууд 2008 оноос эхлэн нэгдсэн байна (UNICEF, 2015). Одоогоор 21 хотод тус санаачлага хэрэгжиж эхлээд байна. Тус санаачлагыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд дараах ажлуудыг хийх ёстой болдог. Үүнд:




1. Хүүхдийн оролцоог хангах
2. Хүүхдэд ээлтэй эрх зүйн орчинг бүрдүүлэх
3. Хүүхдийн эрхийг хамгаалах стратеги боловсруулах
4. Хүүхдийн эрхийг хангах хамтын ажиллагааны механизмыг ажлуулах
5. Хүүхдэд үзүүлж буй нөлөөг хэмжиж үнэлэх
6. Хүүхдийн төсөвтэй болох
7. Хотын хүүхдийн нөхцөл байдлын талаар тогтмол тайлан гаргах
8. Хүүхдийн эрхийг сурталчилан таниулах
9. Хүүхдийг өмгөөлөх бие даасан бүтэц, нэгжийг хөгжүүлэх орно.

Казахстан улсын хувьд хүүхдийн эрхийг хангах чиглэлд орон нутгийн удирдлагын бүтэц, үйл ажиллагаанд үнэлгээ хийхээс эхэлсэн байна. Эндээс хотын засаглалын асуултуудыг дараах бүлэгт хуваасан. Үүнд:

- Хотын бодлого боловсруулахад хүүхдийн оролцоо
- Нийгмийн үйлчилгээ, хамгаалал;
- Боловсрол;
- Чөлөөт цаг, спорт;
- Тээврийн хэрэгсэл;
- Байгаль орчны нөхцөл байдал;
- Нийгмийн эрүүл мэнд;
- Хот төлөвлөлт, нийтийн аж ахуйн ажил;
- Онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээ.

Үүний дараа салбарын бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрт үнэлгээ хийх ажлаас эхэлсэн бөгөөд шалгуур үзүүлэлтүүдийг эрүүл мэнд, хүүхдийн аюулгүй байдал болон амьдрах орчин, нийгмийн тэгш байдал, боловсрол гэсэн дөрвөн үндсэн хэсгээс бүрдэж байсан. Үнэлгээг хийхдээ 8-12 болон 13-17 насны сургуулийн насны хүүхдүүдийн хүрээнд хийсэн байна. Судалгааны асуултуудыг тийм үгүй гэсэн хариулттай байхаар асуусан байна.

Зураг 10. Хүүхдэд ээлтэй хотын 8-12 настай хүүхдээс авах судалгааны асуулгын загвар

I'm <input type="text"/> old					I'm a boy <input type="text"/>		I'm a girl <input type="text"/>	
MY PLAY & ACTIVITIES		Yes	No	I don't know / I prefer not to answer	Comments			
1	 In my neighbourhood, I have places for play and sports.	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>				
2	 I have at least one hour a day to play, rest and enjoy myself at home or in my neighbourhood.	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>				
3	 In my neighbourhood, there is a library or another place where I can find books.	<input type="radio"/>	<input type="radio"/>	<input type="radio"/>				

Эх сурвалж: (UNICEF, 2015)

Асуулгын бүтэц нь

- Миний тоглоом болон соёлын үйл ажиллагаа
- Миний оролцоо болон иргэншил
- Миний аюулгүй байдал болон хамгаалал
- Миний эрүүл мэнд болон амьдрах орчин
- Миний боловсрол
- Миний хувийн амьдрал гэсэн бүлгүүдтэй.

Судалгааг авахдаа хүүхдэд илүү ойлгомжтой энгийн байх тал дээр анхаарч асуулгыг боловсруулсан байна. Асуулгын үр дүнд тулгуурлан орон нутгийн төрийн байгууллага, хүүхэдтэй ажилладаг экспертүүд, хүүхдүүд, эцэг эх олон нийт рүү чиглэсэн тайлан гарах ёстой. Нэг чухал хэсэг нь судалгаанд оролцсон хүүхдүүдтэй үр дүнгээ хуваалцаж, тэдний хэлсэн санал, үзэл бодлыг хэрхэн

тусгаж үнэлэсэнийг харуулах нь чухал болохыг олон улсын зөвлөмжүүдэд заасан байдаг.

ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ХОТЫН ИНДЕКС ТОГТООХ СУДАЛГАА

Дөрөв. Хүүхдэд ээлтэй хотын индекс, шалгуур үзүүлэлт, арга аргачлал

1. “ХҮҮХДИЙН НИЙГМИЙН АМЬДРАЛД ОРОЛЦОХ, ШИЙДВЭР ГАРГАХ ЧАДВАР”

1-р параметрийн үзүүлэлтүүдийн тодорхойлолт

Шалгуур үзүүлэлтийг сонгох үндэслэл:

Хүүхдэд ээлтэй хот нь залуу иргэн бүр өөрийн амьдралд нөлөөлж буй асуудлаар шийдвэр гаргахад нөлөөлөх, хүссэнээрээ хотынхоо талаар санал бодлоо илэрхийлэх эрхийг баталгаажуулдаг. Хүүхдүүд хотын хөгжлийн үйл явцыг мэддэг, энэ үйл явцад оролцож, тэдний санал бодол, туршлагыг хүндэтгэдэг, тэднийг хамтрагч, хувь хүн, тэгш эрхтэй идэвхтэй иргэд гэж хүлээн зөвшөөрдөг гэдгийг бодит амьдрал дээр харах ёстой.

Шалгуур үзүүлэлт бүр нь:

- Үзүүлэлт
- Шалгуур үзүүлэлтийн төрөл
- Үзүүлэлтийг ашиглах зориулалт
- Мэдээлэл цуглуулах арга
- Шалгуур үзүүлэлтийг тооцоолоход хэрэглэгдэх асуултууд
- Шалгуур үзүүлэлтийг тооцоолох арга
- Тооцоолох үзүүлэлт хэвийн утга

Хүүхдийн нийгмийн амьдралд оролцох, шийдвэр гаргах чадвар

1-р параметр

1. Шалгуур үзүүлэлт:

- 1.1. Сүүлийн 12 сард нийслэлийн хэмжээнд 13-17 насны хүүхэд, эцэг эхчүүдийн хувьд хүүхэдтэй холбоотой ямар шийдвэр гарсан талаар мэдээлэл авсан тухай дурдсан
- 1.2. 13-17 насны хүүхэд, эцэг эхчүүдийн хувьд сүүлийн 12 сарын хугацаанд төр, засгийн төлөөлөл хүүхэдтэй холбоотой асуудлаар санал асуулга тавьсан талаар дурдлаа.
- 1.3. Сүүлийн 12 сарын хугацаанд нийгмийн арга хэмжээг бэлтгэх, явуулахад оролцсон 13-17 насны хүүхдийн эзлэх хувь
- 1.4. Сүүлийн 12 сарын хугацаанд сургууль, хотын хэмжээнд өөрөө удирдах байгууллагын сонгууль, түүнчлэн хүүхэд залуучуудын байгууллагын удирдлагын сонгуульд оролцсон 13-17 насны хүүхдийн эзлэх хувь

1.5. 13-17 насны хүүхдийн нийгмийн амьдралд оролцох, шийдвэр гаргахад сэтгэл ханамжийн түвшин, түүнчлэн эцэг эхчүүд хүүхдэд тулгамдаж буй асуудлыг хэлэлцэхэд оролцож байгаад сэтгэл ханамжийн түвшин

2. **Шалгуур үзүүлэлтийн төрөл:** Субъектив шинжтэй.

3. **Шалгуур үзүүлэлтийг ашиглах зориулалт:** Энэхүү шалгуур үзүүлэлтийг ашиглах зориулалт нь хотын түвшинд хүүхдэд нөлөөлөх ямар шийдвэрүүд гаргаж байна вэ? Энэ нь

- 1.1. Хүүхдүүд болон эцэг эхчүүдэд мэдээлэл өгөх ахиц дэвшлийг хэмжихэд ашиглаж байгаа
- 1.2. Энэ үзүүлэлтийг хотын түвшинд хүүхдүүд болон тэдний эцэг эхчүүдтэй хүүхдүүдэд нөлөөлж буй асуудлаар зөвлөлдөх уулзалтыг хэрэгжүүлэх ахиц дэвшлийг хэмжихэд ашигладаг.
- 1.3. Энэ үзүүлэлт нь хүүхдүүдийг нийгэмд ашигтай үйл ажиллагаанд оролцуулж буй түвшний ахилтыг хэмжинэ
- 1.4. Энэ үзүүлэлт нь сургууль, хот, хүүхдийн болон залуучуудын өөрөө удирдах байгууллагад оролцооны түвшний ахилтыг хэмжинэ.
- 1.5. Энэ үзүүлэлтийг хотын хэмжээнд хүүхдийн эрх ашигт хамаарах асуудлаар шийдвэр гаргахад хүүхэд, тэдний эцэг эхийн оролцооны чанарыг хэмжихэд ашигладаг.

4. **Мэдээлэл цуглуулах арга**

- 1.1. 13-17 насны хүүхэд, 0-12 насны хүүхдийн эцэг эхийн судалгаа
- 1.2. 13-17 насны хүүхэд, 0-12 насны хүүхдийн эцэг эхийн судалгаа
- 1.3. 13-17 насны хүүхдийн судалгаа
- 1.4. 13-17 насны хүүхдийн судалгаа
- 1.5. 13-17 насны хүүхэд, 0-12 насны хүүхдийн эцэг эхийн судалгаа

5. **Шалгуур үзүүлэлтийг тооцоолоход хэрэглэгдэх асуултууд**

- 1.1. Уг үзүүлэлтийг "Сүүлийн 12 сарын хугацаанд нийслэлд хүүхдүүдэд нөлөөлөх ямар шийдвэр гарсан талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр эсвэл өөр мэдээлэл авсан уу?" гэсэн асуултын хариултаас үндэслэн тооцдог. Хариултуудын хувьд дараахь хуваарийг ашиглана. тиймээ; үгүй; хариулахаас татгалзах.
- 1.2. Шалгуур үзүүлэлтийг дараах асуултын хариулт дээр үндэслэн тооцдог. "Та сүүлийн 12 сарын хугацаанд хүүхэдтэй холбоотой асуултуудын хэлэлцүүлэгт оролцсон уу?" 13-17 насны хүүхдүүдийн асуулгаас; "Та сүүлийн 12 сарын хугацаанд хүүхэдтэй холбоотой аливаа хүндрэлтэй нөхцөл байдал, түүнийг шийдвэрлэх арга замын талаар Засгийн газраас санаачилсан хэлэлцүүлэгт оролцсон уу?" 0-12 насны хүүхдийн эцэг эхийн асуулгаас. Хариултуудын хувьд дараахь хуваарийг ашиглана. тиймээ; үгүй; хариулахаас татгалзах

- 1.3. Энэ үзүүлэлтийг "Та сүүлийн 12 сарын хугацаанд олон нийтийн арга хэмжээг бэлтгэх, зохион байгуулахад оролцсон уу?" Гэсэн асуултын хариулт дээр үндэслэн тооцдог. Хариултуудын хувьд дараах хуваарийг ашиглана: тийм; үгүй; хариулахаас татгалзах.
- 1.4. Уг үзүүлэлтийг "Сүүлийн 12 сарын хугацаанд сургуулийн болон хотын өөрөө удирдах байгууллагын сонгуульд оролцсон уу?" гэсэн асуултын хариултаас үндэслэн тооцдог. Хариултуудын хувьд дараах хуваарийг ашиглана: тийм; үгүй; хариулахаас татгалзах
- 1.5. Шалгуур үзүүлэлтийг дараахь асуултын хариулт дээр үндэслэн тооцдог. Та өөрийн эрх ашгийг хөндсөн асуудлаар шийдвэр гаргахдаа сэтгэл хангалуун байгаа нь үнэн үү? 13-17 насны хүүхдийн асуулгын хуудас; "Хотын захиргаанаас хүүхдүүдийнхээ эрх ашгийг хөндсөн асуудлаар шийдвэр гаргахад тань татан оролцдог нь үнэн үү?" 0-12 насны хүүхдийн эцэг эхийн асуулгаас. Хариултуудын хувьд дараах хуваарийг ашиглана: 4 - туйлын үнэн, 3 - худалаас илүү үнэн, 2 - ижил хэмжээгээр үнэн худал, 1 - үнэнээс илүү худал, 0 - туйлын худал

6. Шалгуур үзүүлэлтийг тооцоолох арга:

- 1.1. Тоологч: "Тийм" гэж хариулсан хоёр судалгаанд оролцогчдын тоо
Хуваагч: хоёр судалгаанд оролцсон судалгаанд оролцогчдын тоо
Шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар тооцно: $k = \text{тоологч} / \text{хуваагч}$
Тооцоолох үзүүлэлтийн хэвийн утга: $n_{1.1} = 10 * k$
- 1.2. Тоологч: "Тийм" гэж хариулсан хоёр судалгаанд оролцогчдын тоо
Хуваагч: хоёр судалгаанд оролцсон судалгаанд оролцогчдын тоо
Шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар тооцно: $k =$
тоологч/ хуваагч
Тооцоолох үзүүлэлтийн хэвийн утга: $n_{1.2} = 10 * k$
- 1.3. Тоологч: "Тийм" гэж хариулсан хоёр судалгаанд оролцогчдын тоо
Хуваагч: судалгаанд оролцогчдын тоо Шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар тооцно: $k = \text{тоологч} / \text{хуваагч}$
Тооцоолох үзүүлэлтийн хэвийн утга: $n_{1.3} = 10 * k$
- 1.4. Тоологч: "Тийм" гэж хариулсан хоёр судалгаанд оролцогчдын тоо
Хуваагч: судалгаанд оролцогчдын тоо
Шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар тооцно: $k =$
тоологч/ хуваагч
Тооцоолох үзүүлэлтийн хэвийн утга: $n_{1.4} = 10 * k$

- 1.5. Тоологч: $4*a + 3*b + 2*c + 1*d + 0*e$, энд а нь "туйлын үнэн" гэж хариулсан хоёр судалгаанд оролцогчдын тоо, b - "худалаас илүү үнэн" гэж хариулсан судалгаанд оролцогчдын тоо. худал', в - 'ижил хэмжээгээр үнэн худал' гэж хариулсан судалгаанд оролцогчдын тоо, d - 'үнэнээс илүү худал' гэж хариулсан судалгаанд оролцогчдын тоо, е - "туйлын худал" гэж хариулсан судалгаанд оролцогчдын тоо. Хуваагч: хоёр судалгаанд оролцсон судалгаанд оролцогчдын тооШалгуур үзүүлэлтийг дараах байдлаар тооцно: $k = \text{тоологч} / \text{хуваагч}$
Тооцоолох үзүүлэлтийн хэвийн утга: $n1.5 = k/4*10$

Нормчилсан параметрийн утгыг дараах томъёогоор тооцоолно.

$$P1 = (n1.1. + n1.2. + n1.3. + n1.4. + n1.5.) / 5$$

2. АМЬДРАХ ОРЧИН

2-р параметрийн үзүүлэлтүүдийн тодорхойлолт

Шалгуур үзүүлэлтийг сонгох үндэслэл: Хүүхдэд ээлтэй хот нь залуу иргэн бүр өөрийн амьдралд нөлөөлж буй асуудлаар шийдвэр гаргахад нөлөөлөх, хүссэнээрээ хотынхоо талаар санал бодлоо илэрхийлэх эрхийг баталгаажуулдаг. Хүүхдүүд хотын хөгжлийн үйл явцыг мэддэг, энэ үйл явцад оролцож, тэдний санал бодол, туршлагыг хүндэтгэдэг, тэднийг хамтрагч, хувь хүн, тэгш эрхтэй идэвхтэй иргэд гэж хүлээн зөвшөөрдөг гэдгийг бодит амьдрал дээр харах ёстой.

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:

- 2.1. Хүүхдийн тэрэг, тэргэнцэрт саадгүй нэвтрэх зориулалттай тавилгатай байшингийн эзлэх хувь
- 2.2. Орон сууц/гэрт тусдаа хүүхдийн өрөө байдаг гэж дурдсан 6-17 насны хүүхдүүдийн эзлэх хувь
- 2.3. Гэрийнхээ ойролцоо тохижуулсан тоглоомын талбайтай газар байдаг талаар дурдсан 6-12 насны хүүхдүүд болон эцэг эхчүүдийн эзлэх хувь
- 2.4. Тавилгатай тоглоомын талбай, хүүхэд спортоор хичээллэх боломжтой гэж дурдсан 6-17 насны хүүхдүүдийн эзлэх хувь
- 2.5. Гэрийнхээ ойролцоо хүүхэд байгальтай харьцах боломжтой газар (хамгийн ихдээ 15 минут алхах зай) байдаг талаар дурдсан 6-17 насны хүүхдүүд болон эцэг эхчүүдийн эзлэх хувь (минипарк, цэцэрлэгт хүрээлэн, далан)
- 2.6. Гэр орчноо цэвэрхэн, хоггүй гэж хэлсэн 6-17 насны хүүхдүүд болон эцэг эхчүүдийн эзлэх хувь
- 2.7. 6-17 насны хүүхэд, эцэг эхийн амьдрах орчны нөхцөл байдалд сэтгэл ханамжийн түвшин

Нормчилсан параметрийн утгыг дараах томъёогоор тооцоолно.

$$P2 = (n2.1. + n2.2. + n2.3. + n2.4. + n2.5. + n2.6. + n2.7.) / 7$$

3. ХОТЫН ХҮҮХДИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

3-р параметрийн үзүүлэлтүүдийн тодорхойлолт

Шалгуур үзүүлэлтийг сонгох үндэслэл:

Хүүхдэд ээлтэй хот нь залуу иргэн бүрийн мөлжлөг, хүчирхийлэл, аюулаас хамгаалагдах эрхийг баталгаажуулдаг. Хүүхдийг эрүүл мэнд, бие бялдар, оюун ухаан, оюун санаа, ёс суртахуун, нийгмийн хөгжилд сөргөөр нөлөөлж болзошгүй үйлдлээс хамгаалах ёстой.

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:

- 3.1. 0-17 насны хүүхдийн гэмтэл, хордлого болон гадны нөлөөллийн бусад зарим үр дагавраас үүдэлтэй өвчлөлийн түвшин
- 3.2. Гэмт хэргийн хохирогч болсон насанд хүрээгүй (0-17 насны хүүхэд)-ийн эзлэх хувь
- 3.3. 5-17 насны хүүхэд залуучуудын нас баралтын түвшин
- 3.4. Сүүлийн 12 сарын хугацаанд хүүхдүүдээ бие махбодийн болон сэтгэл зүйн хүчирхийлэлд өртөөгүй гэж хэлсэн 6-17 насны хүүхдүүд болон эцэг эхчүүдийн эзлэх хувь
- 3.5. 6-17 насны хүүхэд, эцэг эхчүүдийн хувьд хотод амьдрахад аюулгүй гэж бодож буй эзлэх хувь

Нормчилсан параметрийн утгыг дараах томъёогоор тооцоолно.

$$P3 = (n3.1. + n3.2. + n3.3. + n3.4. + n3.5.) / 5$$

4.ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ, ЭРҮҮЛ АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГ

4-р параметрийн үзүүлэлтүүдийн тодорхойлолт

Шалгуур үзүүлэлтийг сонгох үндэслэл:

Хүүхдэд ээлтэй хот гэдэг нь бүх залуу иргэд эрүүл мэндийн үйлчилгээтэй байхыг илэрхийлнэ. Хүүхэд бүр эрүүл байхын тулд чанартай эрүүл мэндийн үйлчилгээ, мэдлэг, чадвар авах ёстой.

- 4.1. 0-4 насны хүүхдийн нас баралтын түвшин

- 4.2. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан 6-17 насны архаг өвчтэй буюу хөгжлийн бэрхшээлтэй гэж тооцогдсон хүүхдийн эзлэх хувь (эрүүл мэндийн 3, 4-р бүлгийн сургуулийн насны хүүхдүүд)
- 4.3. 15-19 насны охидын жирэмслэлт тасалдсан тохиолдол
- 4.4. ХДХВ/ДОХ, хүсээгүй жирэмслэлт, бэлгийн замын халдварт өвчний талаар эмчийн зөвлөгөө авах боломжтой гэж дурдсан 13-17 насны хүүхдүүдийн эзлэх хувь
- 4.5. Сүүлийн нэг сард тамхи тобакко бүтээгдхүүн 13-17 насны хүүхдийн эзлэх хувь
- 4.6. Сүүлийн 6 сарын хугацаанд согтууруулах ундаа, зөөлөн согтууруулах ундаа хэрэглээгүй 13-17 насны хүүхдийн эзлэх хувь
- 4.7. Мансууруулах бодис хэрэглэж байгаагүй 13-17 насны хүүхдийн эзлэх хувь
- 4.8. 13-17 насны хүүхэд, эцэг эхийн эрүүл мэндийн үйлчилгээнд сэтгэл ханамжийн түвшин

Нормчилсан параметрийн утгыг дараах томъёогоор тооцоолно.

$$P4 = (n4.1. + n4.2. + n4.3. + n4.4. + n4.5. + n4.6. + n4.7. + n4.8..) / 8$$

5. БОЛОВСРОЛ БА ХӨГЖИЛ

5-р параметрийн үзүүлэлтүүдийн тодорхойлолт

Шалгуур үзүүлэлтийг сонгох үндэслэл:

Хүүхдэд ээлтэй хот нь залуу иргэн бүрийн сурч боловсрох эрхийг баталгаажуулдаг. Хүүхэд хүйс, ярьж буй хэл, итгэл үнэмшил, үндэс угсаа, үндэс угсаа, нийгмийн байдал, эд хөрөнгийн байдал, эрүүл мэнд болон бусад нөхцөл байдлаас үл хамааран бие бялдар, оюун ухаан, оюун санаа, ёс суртахуун, сэтгэл зүй, нийгмийн хөгжилд шаардлагатай чанартай боловсрол эзэмших боломжтой байх ёстой.

- 5.1. Хотын боловсролын байгууллагуудын 9-р ангиас хойшхи шалгалтын дундаж оноо
- 5.2. Гэр, ажлын байрны ойролцоо байрлах хүүхдийн цэцэрлэг, цэцэрлэгт хамрагдах боломжтой эцэг эхчүүдийн эзлэх хувь
- 5.3. Мэргэшсэн боловсролын байгууллагад суралцаж буй 6-17 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эзлэх хувь

- 5.4. 6-17 насны хүүхдүүд өөрсдийн эрхээ насанд хүрэгчдэд хэлж чадахуйц сайн мэддэг гэж хариулсан хүүхдүүдийн эзлэх хувь
- 5.5. Нийслэлийн боловсролын чанарт 6-17 насны хүүхэд, эцэг эхчүүдийн сэтгэл ханамжийн зэрэг

Нормчилсан параметрийн утгыг дараах томъёогоор тооцоолно.

$$P5 = (n5.1 + n5.2 + n5.3 + n5.4 + n5.5) / 5$$

6. ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛ

6-р параметрийн үзүүлэлтүүдийн тодорхойлолт

Шалгуур үзүүлэлтийг сонгох үндэслэл:

Хүүхдэд ээлтэй хот нь залуу иргэн бүр хотын соёлын амьдралд оролцох эрхийг баталгаажуулдаг. Хүүхдүүд өөрсдийн хоббитой уялдуулан өргөтгөсөн боловсролын байгууллага, клуб, спортын байгууллагад суралцах, зуны улиралд эрүүл мэндээ сайжруулах боломжтой байх ёстой.

- 6.1. Хүүхэд залуучуудын өргөтгөсөн боловсрол олгох байгууллага, төрөлжсөн сургалт, спортын байгууллага, олимпийн нөөцийн сургууль, клубт боловсрол эзэмшиж буй 6-17 насны хүүхдийн эзлэх хувь
- 6.2. Зуны амралтаар Монгол улсаас гадуур сургуульд эсвэл хотоос гадуур зусланд долоо хоногоос дээш хугацаагаар амарч, явган аялал хийсэн эсвэл амарч байсан 6-17 насны хүүхдүүдийн эзлэх хувь
- 6.3. Сүүлийн 12 сарын хугацаанд соёлын арга хэмжээ (тоглолт, цирк, концерт, үзэсгэлэн) үзсэн 6-17 насны хүүхдийн эзлэх хувь
- 6.4. 14-17 насны, шаардлагатай тохиолдолд хичээлээс чөлөөлөгдсөн цагийн ажилд орох боломжтой хүүхдийн эзлэх хувь
- 6.5. Хотын хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх тогтолцоонд 6-17 насны хүүхэд, эцэг эхчүүдийн сэтгэл ханамжийн зэрэг

Нормчилсан параметрийн утгыг дараах томъёогоор тооцоолно.

$$P6 = (n6.1 + n6.2 + n6.3 + n6.4 + n6.5) / 5$$

7. АМЬДРАЛЫН ХҮНД НӨХЦӨЛД ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ

7-р параметрийн үзүүлэлтүүдийн тодорхойлолт

Шалгуур үзүүлэлтийг сонгох үндэслэл:

Хүүхдэд ээлтэй хот нь залуу иргэн бүр амьдралын хүнд нөхцөлд хамгаалагдах, дэмжлэг үзүүлэх эрхийг баталгаажуулдаг

- 7.1. Нийслэлд 0-17 насны хүүхдүүдийн нийгмийн эрсдэлд тооцогдож, оны эцсийн бүртгэлд хамрагдсан хүүхдийн эзлэх хувь
- 7.2. Жилийн хугацаанд тогтоогдсон, асран хүмүүжүүлэх гэр бүлд олгосон өнчин, эцэг эхийн асрамжгүй хүүхдүүдийн эзлэх хувь
- 7.3. Цагдаагийн бүртгэлтэй насанд хүрээгүй хүмүүсийн эзлэх хувь
- 7.4. Хариуцлагатай хүмүүжлийн талаар зөвлөгөө, сургалтанд хамрагдсан эцэг эхчүүдийн эзлэх хувь
- 7.5. 6-17 насны хүүхдийн эцэг, эхийн мэдэлгүйгээр холбогдох мэргэжилтэнтэй холбоо барих, тусгай утас руу залгаж асуудлаа ярилцах боломжтой хүүхдийн эзлэх хувь
- 7.6. 13-17 насны хүүхдүүд болон эцэг эхчүүдийн хүнд нөхцөлд байгаа хүүхдүүдэд тусламж үзүүлэх тогтолцоонд сэтгэл ханамжийн зэрэг

Нормчилсан параметрийн үтгыг дараах томъёогоор тооцоолно.

$$P_7 = (n_{7.1} + n_{7.2} + n_{7.3} + n_{7.4} + n_{7.5} + n_{7.6}) / 6$$

Жич: Долоон үндсэн үзүүлэлт дотроо хамгийн ихдээ 7, хамгийн багадаа 5 үндсэн үзүүлэлтээр хэмжигдэнэ. Параметр нь 7 үзүүлэлт доторх асуултын дундаж, индекс нь 7 параметрийн дундажаар хэмжигдэнэ. Хамгийн дээд авах оноо бол 10 оноо байна.

Хотын хүүхдэд ээлтэй байдлын индексийн тооцоо:

$$I = (P1 + P2 + P3 + P4 + P5 + P6 + P7) / 7$$

Түүвэр хийх аргачлал

Хотын ангилал	6-12 насны хүүхэд	13-17 насны хүүхэд	0-12 нас эцэг эх	Түүврийн бүтэц
Хот	200+20	200+20	200+20	+Нийслэлийн түвшинд бүх дүүрэг оролцоотой байх. +Багадаа 20 боловсролын өөр байгууллага, сургуулийн хамарсан байх. +Хүйсийн бүтэц (50%+5%) +(0-6) настай хүүхдийн эцэг эх +(7-12) настай хүүхэд (50%+5%)
Орон нутаг	150+15	150+15	150+15	+Багадаа 15 боловсролын өөр байгууллага, сургуулийн хамарсан байх. +Хүйсийн бүтэц (50%+5%) +(0-6) настай хүүхдийн эцэг эх +(7-12) настай хүүхэд (50%+5%)
	100+10	100+10	100+10	+Багадаа 5 боловсролын өөр байгууллага, сургуулийн хамарсан

Дүүрэг			байх. +Хүйсийн бүтэц (50%+5%) +(0-6) настай хүүхдийн эцэг эх +(7-12) настай хүүхэд (50%+5%)
--------	--	--	---

Нарийвчилсан судалгааг хийхдээ:

1. Асуултанд хариулагчдыг санамсаргүй тохиолдлоор сонгох,
2. Асуулт хариултыг боловсролын байгууллагатай нь хамтран кампус дээр явуулах,
3. Асуултын хариултыг өөр өөр цаг хугацаанд явуулснаар янз бүрийн (1-12 ангийн) янз бүрийн хүүхдүүдийн төлөөлөлөөс авах

ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ХОТЫН ИНДЕКС ТОГТООХ СУДАЛГАА

Тав. Чанарын судалгааны ярилцлагын удирдамж

- 5.1. Хүүхдийн нийгмийн оролцоо шийдвэр гаргах чиглэлээр мэдээлэл цуглуулах, боловсруулах
- 5.2. Хүүхдийн амьдрах орчны талаарх тоон болон статистик мэдээлэл цуглуулах боловсруулах
- 5.3. Хүүхдийн аюулгүй байдлын талаарх мэдээлэл цуглуулах боловсруулах
- 5.4. Хүүхдийн эрүүл мэнд эрүүл амьдралын хэв маягийн талаарх мэдээлэл цуглуулах боловсруулах
- 5.5. Хүүхдийн боловсрол ба хөгжлийн талаарх мэдээлэл цуглуулах боловсруулах
- 5.6. Хүүхдийн чөлөөт цаг соёл хүмүүжлийн ажлын талаарх мэдээлэл цуглуулах боловсруулах
- 5.7. Хүүхдэд нэн шаардлагатай үйлчилгээний хүртээмжийн талаархи мэдээлэл цуглуулах боловсруулах

Нэг. Хүүхдийн нийгмийн оролцоо шийдвэр гаргах чиглэлээр мэдээлэл цуглуулах боловсруулах (5.1)

Асуулга чиглэл: “Хүүхдийн нийгмийн оролцоог судлах байдал”

Зорилго: “Хүүхдэд ээлтэй хотын индекс тогтоох судалгаа” сэдвийн хүрээнд эксперт, мэргэжилтэнтэй ярилцаж мэдээлэл цуглуулах удирдамж

1. Хүүхдийн нийгмийн оролцох эрхийн талаар НҮБ-ын баримт бичгүүдэд ямар зүйл заалт байдаг вэ?
2. Хүүхдийн нийгмийн оролцох эрхийн тухай Монгол улсын хуулиудад хэрхэн тусгасан байдаг вэ? /баримт бичиг, тушаал шийдвэр, тушаал тогтоолууд сүүлийн 3 жилд /
3. Хүүхдийн нийгмийн оролцооны тухай Монгол улсад ямар судалгаа хийгдэж байсан бэ?
4. Тухайн дэвсгэр дээрх хүүхдүүдийн нийгмийн амьдралд оролцооны талаарх ямар судалгаа байдаг вэ?
5. Судалгаагаар ямар статистик тоо баримт гарсан бэ?
6. Хүүхдийн нийгэмд оролцох эрхийг хангах ямар ямар үйл ажиллагаа явуулдаг вэ?
7. Тухайн үйл ажиллагаанд хичнээн хүүхэд оролцсон байдаг вэ?
8. Тухайн үйл ажиллагаа нь жил бүр уламжлал болгон зохиогддог уу?
9. Тухайн үйл ажиллагаанд өөрийн төсөв санхүү байдаг уу?
10. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцох эрхийг хангах тал дээр ямар үйл ажиллагаа явуулдаг вэ?
11. Тэрхүү үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд бүрэн хамрагдаж чаддаг уу?

12. Зохион байгуулсан үйл ажиллагаа бүр нь дүүрэгт байгаа хүүхэд бүрт хүрч чаддаг уу?
13. Үйл ажиллагаа зохион байгуулахад тулгамдаж буй асуудал нь юу вэ?
14. Хүүхдийн оролцоог хангах тал дээр одоо хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, үйл ажиллагаа байгаа юу?
15. Дүүргийн удирдлагуудаас хүүхдийн оролцоог хэрхэн дэмжиж ажилладаг вэ?
16. Энэ чиглэлээр Улаанбаатар хотын 9 дүүргээс аль дүүрэг нь илүү санаачлагатай ажилладаг вэ?
17. Олон нийтийн байгууллагатай хамтарч ямар чиглэлээр ямар үйл ажиллагааг илүү дэмжиж ажилладаг вэ?
18. Боловсролын байгууллагатай хамтарч ямар үйл ажиллагаа явуулдаг вэ?
19. Хүүхдийн нийгмийн амьдралд оролцох эрх зөрчигдсэн байдлыг хэрхэн шийдвэрлэдэг вэ?
20. Хүүхдийн нийгмийн оролцоог хангахад цаашид юуг анхаарах хэрэгтэй вэ?
21. Хүүхдийн нийгмийн оролцоог сайжруулахад юуг анхаарах вэ?

Хоёр. Хүүхдийн амьдрах орчны талаарх тоон болон статистик мэдээлэл цуглуулах боловсруулах (5.2)

Асуулга чиглэл: “Хүүхдийн амьдрах орчныг судлах асуулгын удирдамж”

Зорилго: “Хүүхдэд ээлтэй хотын индекс тогтоох судалгаа” сэдвийн хүрээнд мэргэжилтэнтэй ярилцаж мэдээлэл цуглуулах удирдамж

Асуулга

1. Хүүхдийн амьдрах орчин гэж юу вэ?
2. Хүүхдийн амьдрах орчин ямар байх ёстой бэ?
3. Хүүхдийн амьдрах орчны талаар ямар эрх зүйн баримт бичиг байна вэ?(Олон улсын баримт бичиг)
4. Хүүхдийн амьдрах орчинд хийгдсэн ямар шалгуур байдаг вэ?
5. Хүүхдийн амьдрах орчин Нийслэлийн хүрээнд одоогийн байдлаар ямар нөхцөл байдалд байна вэ?
6. Хүүхдийн амьдрах орчинг бүрдүүлсэн хамгийн сайн ажиллаж байгаа хороо, дүүрэг аль нь вэ?
7. Нийслэл, орон нутаг, үндэстний хэмжээнд хийгдсэн судалгаа байгаа юу?
8. Хүүхдийн амьдрах орчноор ямар үйл ажиллагаа хийгддэг вэ?
9. Хүүхдийн амьдрах орчныг сайжруулахад дүүрэг хороонд жилд хэр хэмжээний төсөв хувиарлагддаг вэ?
10. Одоогийн байдлаар хийгдэж байгаа бодит ажил байгаа юу?
11. Хүүхдийн амьдрах орчинд Нийслэлийн хэмжээнд сайжруулахтай холбоотой ямар бэрхшээл байна вэ?
12. Таны бодолоор юу хийвэл хүүхдийн амьдрах орчин хангагдана гэж үздэг вэ?

13. Та цаашид юу хийвэл зохистой вэ?
14. Та ямар үр дүнд хүрээсэй гэж боддог вэ?
15. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн амьдрах орчин юугаараа ялгаатай вэ?
16. Тусгай хэрэгцээт боловсролыг нийслэлийн хэмжээнд ХБХ-үүд бүгд хамрагдаж чадаж байгаа юу?
17. Тэгш хамруулах, ХБХ-ийн сургууль, цэцэрлэг Нийслэлийн хэмжээнд хэд байгаа вэ?
18. ХХБХ-д таатай сурах орчин нөхцөлийг бүрдүүлж чадаж байна уу?

Гурав. Хүүхдийн аюулгүй байдал тоон болон статистик мэдээлэл цуглуулах боловсруулах (5.3)

Асуулга чиглэл: **“Хүүхдийн аюулгүй байдал” удирдамж**

Зорилго: МУ хүүхдийн аюулгүй орчин нөхцөлд амьдрах стандартыг мөрдөж ажилладаг эсэх талаар болон төр, эрх зүйн орчныг нь судлахад оршино.

Үйл ажиллагаа: Мэргэжлийн ажилтанаас дараах асууж асуулгын аргаар судалгаа авна.

1. Хүүхдийн аюулгүй байдлын стандартыг тусгасан судалгаа тоон мэдээлэл байгаа юу?
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн аюулгүй байдлыг хангах хууль эрх зүйн зохицуулалт байгаа юу?
3. Төрөөс хүүхдийн аюулгүй байдлыг ханган хамгаалж чадаж байгаа юу?
4. Чадаж чадаж байгаа бол яаж? Чадахгүй байгаа бол яагаад?
5. МУ-д хүүхдийн аюулгүй байдлын стандартыг ямар шаардлагаар тогтоодог вэ?
6. Хүүхдийн аюулгүй байдлын стандартыг ямар байгууллагаас тодорхойлдог вэ?
7. Төрөөс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах төв болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах ТББ болон төвүүдэд ямар нэгэн дэмжлэг тусалцаа байдаг уу?
8. Дэмжлэг тусалцаа, санхүүжилт өгдөг бол хэр хэмжээний төсвөөр дэмжлэг тусалцаа үзүүлдэг вэ?
9. Монгол улсад 2019 оноос хойш хийгдсэн хүүхдийн аюулгүй байдлын стандарттай холбоотой судалгаа тоон мэдээлэл байгаа юу?
10. Олон улсын байгууллагаас ямар ямар төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг вэ?

Дөрөв. Хүүхдийн эрүүл мэнд эрүүл амьдралын хэв маягийн талаарх мэдээлэл цуглуулах боловсруулах (5.4)

“Хүүхдийн эрүүл мэнд” сэдэвт ганцаарчилсан ярилцлагын удирдамж

1. Хүүхдийн эрүүл мэнд гэж юуг ойлгох вэ?
2. Хүүхдийн эрүүл мэндийн талаар эрх зүйн ямар зохицуулалт байдаг вэ?

3. Хүүхдийн эрүүл мэндийн хүрээнд тулгамдаж буй ямар асуудлууд байна вэ? Таны бодлоор үүнийг хэрхэн шийдвэл зохих вэ?
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд рүү чиглэсэн эрүүл мэндийн үзлэг үйлчилгээ байдаг уу?
5. Нийслэлийн хэмжээнд хүүхдийн эрүүл мэндийн хүрээнд сүүлийн 3 жилд авч хэрэгжүүлсэн томоохон үйл ажиллагаанаасаа дурьдна уу? Үүнд хэдэн хүүхэд хамрагдсан бэ?
6. Хүүхдийн эрүүл мэндийн асуудлыг хариуцсан ямар ямар байгууллага байдаг вэ?
7. Нийслэл дүүргийн хэмжээнд хүүхдийн эрүүл мэндийн талаар судалгааны ямар ажлууд хийсэн бэ? \ томуу, томуу тус өвчин, агаарын бохирдол г.м\
8. Төрөөс эрүүл мэндийн салбарт хэдэн төгрөгийн санхүүжилт орж ирдэг вэ?
9. Эрүүл мэндийн салбарт орж ирж байгаа санхүүжилтын хэдэн хувь нь хүүхдийн эрүүл мэндэд зарцуулагддаг вэ?
10. Хүүхдийн эрүүл мэндийн орчинг эрх зүйгээр хэрхэн зохицуулж өгдөг вэ?
11. Хүүхдийн эрүүл мэндтэй холбоотой ямар үйл ажиллагаа явуулбал зохих вэ?

Тав. Хүүхдийн боловсрол ба хөгжлийн талаарх мэдээлэл цуглуулах боловсруулах (5.5)

“Хүүхдийн хөгжил ба боловсрол” сэдэвт ганцаарчилсан ярилцлагын удирдамж

Зорилго: Хүүхдийн хөгжил ба боловсролын талаар мэдээлэл цуглуулахад оршино.

1. Хүүхдийн хөгжил гэдэгт юуг ойлгох вэ? Боловсролтой хэрхэн холбогдож байна вэ?
2. Хүүхдийн хөгжлийн талаар тусгагдсан ямар хууль эрх зүйн, бодлого дүрэм журам байдаг вэ?
3. Хүүхдийн хөгжлийн талаар олон улсын баримт бичигт хэрхэн тусгагдсан байдаг вэ?
4. Хүүхдийн хөгжлийн ба боловсролын тухай гаргасан тушаал, тогтоолууд байна уу?
5. Хүүхдийн хөгжил ба боловсролд хийгдсэн суурь судалгаа байна уу?
6. Хүүхдийн хөгжил ба боловсролын талаар үйл ажиллагаа явуулдаг шалгарсан ямар дүүрэг байна вэ?
7. Хүүхэд бүр хэрэгцээндээ нийцсэн хөгжлийн дэмжлэг, боловсролын үйлчилгээ авч чадаж байна уу? Чадахгүй бол яагаад? Яагаад авч чадахгүй байна вэ?
8. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаа байна уу? Асуудалд хэрхэн анхаарч хэрхэн анхаарч ажиллаж байна вэ?

9. Хүүхдийн сурч боловсрох, хөгжих таатай орчинг бүрдүүлэхэд сургуулийн өмнөх боловсролын хамрах сургалт хангалттай хэмжээнд явагдаж байгаа юу?
10. Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай сургуулийн өмнөх насны хүүхдийг эрт илрүүлж хөгжүүлснээр ердийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд элсэн суралцах боломжийг хангаж дэмжлэг үзүүлж байгаа юу?
11. СӨБ-д хамруулахгүй гэртээ хүүхдээ асарч сувилдаг эцэг, эхчүүдэд ямар мэдээ мэдээллийг өгдөг вэ?
12. Хүүхдийн хөгжил, боловсролын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр цаашид юу хийхэд шаардлагатай вэ? Тулгамдсан асуудлуудыг нэрлэнэ үү.

Зургаа. Хүүхдийн чөлөөт цаг соёл хүмүүжлийн ажлын талаарх мэдээлэл цуглуулах боловсруулах удирдамж (5.6)

Хүүхдийн хөгжлийн чөлөөт цаг соёл хүмүүжлийн ажил

1. Хүүхдийн хөгжлийн чөлөөт цаг соёл хүмүүжлийн ажил гэдэгт юуг ойлгох вэ?
2. Хүүхдийн хөгжлийн чөлөөт цаг соёл хүмүүжлийн талаарх эрх зүйн зохицуулалт бий юу?
3. Энэ чиглэлээр хийгдсэн судалгаа бий юу?
4. Төрөөс хүүхдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх орчин нөхцлийг хангаж чадаж байна уу?
5. Хүүхдийн соёл хүмүүжлийн ажлыг хариуцдаг байгууллага, түүний үйл ажиллагаа, үндсэн чиглэл нь юу вэ?
6. Хүүхдийн чөлөөт цаг соёл хүмүүжлийн ажлын дагуу төрөөс ямар дэмжлэг үзүүлж байна вэ?
7. Хүүхдийн хөгжлийн чөлөөт цаг соёл хүмүүжлийн ажилд жилд хичнээн төгрөгний төсөв зарцуулдаг вэ?.
8. Энэ чиглэлийн төсөв санхүүг хэн хариуцаж ажилладаг вэ?
9. Хүүхэд залуучуудын өргөтгөсөн боловсрол олгох сургалт зохион байгуулж байсан уу?
10. Хүүхдэд зориулсан дугуйлан клуб хэр хүртээмжтэй байна вэ?
11. Хүүхдийн хөгжлийн чөлөөт цаг соёл хүмүүжлийн ажилд нэн тэргүүнд тулгамдаж буй асуудал юу байна вэ?
12. Хүүхдийн чөлөө цаг зөв боловсон өнгөрүүлэх орчинг нэмэгдүүлэх боломж хэр байна вэ?
13. Хүүхдийн хөгжлийн чөлөөт цаг соёл хүмүүжлийн ажилд авч хэлэлцэх асуудал бий юу?
14. Тухайлбал танай дүүрэгт хүүхдийн чөлөөт цагаа өнгөрүүлэх орчин хэр хүртээмжтэй байна вэ?
15. Хүүхдүүд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхэд зориулсан орчин эрүүл ахуйн шаардлага хангаж чадаж байна уу?

Долоо. Хүүхдэд нэн шаардлагатай үйлчилгээний хүртээмжийн талаархимэдээлэл цуглуулах боловсруулах (5.7)

Хүүхдэд нэн шаардлагатай үйлчилгээний хүртээмжийн талаарх мэргэжилтэнтээс асуух асуултуудын удирдамж

1. Хүүхдэд нэн шаардлагатай үйлчилгээ гэдэгт юуг ойлгох вэ? Ямар ямар үйлчилгээ энд орох вэ?
2. Нийслэлийн хэмжээнд хүүхдэд нэн шаардлагатай үйлчилгээ явуулдаг байгуулагуудын хүртээмж ямар түвшинд байна вэ?
3. Хүүхдэд нэн шаардлагатай үйлчилгээг авах хууль эрх зүйн орчин хэр бүрдсэн вэ? Ямар эрх зүйн баримт бичиг байна вэ? Нэрлэнэ үү?
4. Хүүхдийн хөгжлийн хэрэгцээ оролцоонд суурилсан хууль тогтоомжийн хэрэгжилт ямар байгаа вэ?
5. Эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулахтай холбоотой ямар эрх зүйн зохицуулалт байна вэ?
6. Нийслэлийн нийт дүүргийн хэмжээнд хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээг явуулдаг эмнэлэгийн хүртээмж хэр байгаа вэ?
7. Боловсролын үйлчилгээг сайжруулахтай холбоотой ямар эрх зүйн зохицуулалт байна вэ?
8. Нийслэлийн нийт дүүргийн хэмжээнд хүүхдийн боловсролын үйлчилгээг явуулдаг сургуулийн хүртээмж хэр байгаа вэ?
9. Боловсролын үйлчилгээ чанартай байж чадаж байгаа юу?
10. Хүүхдэд нэн шаардлагатай үйлчилгээний хүртээмжийн талаархи ямар ямар судалгаа сүүлийн 3 жилийн хугацаанд хийгдсэн бэ?

Ашигласан материал, баримт бичгүүд

А. Олон улсын болон үндэсний хууль тогтоомж

1. Ажил эрхлэх насны доод хязгаарын тухай Олон улсын хөдөлмөрийн зөвлөмж №146
2. Монгол Улсын Үндсэн хууль, УБ, 1992
3. Монгол улсын Боловсролын тухай хууль. УБ., 2002, 2006
4. Монгол Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, УБ, 1996
5. МУ-ын Хөдөлмөрийн тухай хууль, УБ, 1998 он
6. Монгол Улсын Засгийн газрын Мөрийн хөтөлбөр
7. НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай Конвенц (1989 онд батлагдсан, Монгол улс 1990 онд нэгдэн орсон)
8. Олон улсын хөдөлмөрийн Конвенц №138. Ажил эрхлэх насны доод хязгаарын тухай (ОУХБ-аас 1973 онд батлагдсан, Монгол улс 2002 онд нэгдэн орсон)
9. Олон улсын хөдөлмөрийн Конвенц №182. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай (ОУХБ-аас 1999 онд батлагдсан)
10. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай Олон улсын Пакт (1966 онд батлагдсан, Монгол улс 1974 онд нэгдэн орсон)

Б. Судалгаа, ном товхимол

Монгол хэл дээрх

1. АХИС, ЗХЖТ. Хүүхдийн бие махбод болон сэтгэл санааны эсрэг шийтгэл: хүүхдэд үйлчилгээ үзүүлдэг байгууллагын орчинд, хүүхдийн үзэл бодол\ судалгааны дүнгийн товч тайлан. Уб., 2005
2. АХИС. Хүүхдийг нийгэмшүүлэх тоглоомууд. Уб., 2006
3. БСШУЯ, НҮБ-ын Хүүхдийн сан. Сургуулийн хүүхдэд ээлтэй байдлыг үнэлэх асуулга. Уб., 2007
4. БСШУЯ. ЕБС-д суралцдаггүй 6-14 насны хүүхэд. 2008-2009
5. З.Боаз. Анги удирдах урлаг. Уб., 2006
6. Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр. Уб., 2003
7. Монгол Улсын Засгийн газрын Мөрийн хөтөлбөр
8. МУБИС. Хүүхдийн эрхийн боловсрол. Уб, 2007
9. МУБИС, Сургууль, цэцэрлэгийн орчин дахь хүүхдийн эсрэг хүчирхийлэл, түүнийг арилгах арга зам. Судалгааны тайлан. Уб., 2007
10. МУ-ын Үндэсний Статистикийн Хороо, Монголын хүүхдийн хөдөлмөрийн судалгааны тайлан. Уб хот, 2008
11. НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны 39-р чуулганаас хүүхдийн эрхийн асуудлаар Монгол улсад өгсөн зөвлөмж. Уб., 2005
12. НҮБ-ын Хүүхдийн сан, ОУХБ, Английн Хүүхдийг Ивээх сан. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын хүүхдийн эсрэг хүчирхийллийн судалгаа. Хүүхэд залуучуудад зориулсан хувилбар. Уб., 2006
13. НҮБ-ын Хүүхдийн сан. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн дэлхийн тайлан, Хүүхэд залуучуудад зориулсан хувилбар. Уб. 2007
14. НҮБ-ын Хүүхдийн сан. “Монгол Улсын хүүхэд эмэгтэйчүүдийн байдал” Судалгааны тайлан. Уб. 2007

15. ОУХБ. НҮБ-ийн Хүүхдийн сан. Дэлхийн банк. Монгол улсын хүүхдийн хөдөлмөр ба залуучуудын ажил эрхлэлтийг ойлгохуй. Судалгааны тайлан. 2009. 10 дахь тал
16. НҮБ-ын Хүүхдийн сан. Дэлхийн хүүхдийн байдал. 2009
17. НХХЯ, ОУХБ, Хүүхдийн хөдөлмөрийн холбогдолтой хууль тогтоомжийн эмхтгэл. УБ., 2005
18. ОУХБ, Хүүхдийн хөдөлмөрийг устгах: Хүрч болох зорилт, дэлхийн илтгэл, 2006
19. ОУХБ, Хүүхдийн хөдөлмөр, Их дээд сургуулийн оюутнуудад зориулсан сурах бичиг, Хүүхдийн хөдөлмөрийг устгах Олон улсын хөтөлбөр
20. ОУХБ. НҮБ-ийн Хүүхдийн сан. Дэлхийн банк. Монгол улсын хүүхдийн хөдөлмөр ба залуучуудын ажил эрхлэлтийг ойлгохуй. Судалгааны тайлан. 2009. 2 дахь тал
1. Төрийн мэдээлэл. Тусгай дугаар. I боть. Монгол Улсын олон улсын гэрээ. УИХТГ, ГХЯ, УБ., 2004
2. Сургууль завсардалт. Судалгааны тайлан. БХАН. 2005
3. К.Портес нар. Бие махбодийн шийтгэлээс бусад хүмүүжлийн аргууд, УБ., 2005
4. Парламентын гишүүдэд зориулсан гарын авлага №3-2002, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах нь, ОУХБ-ын 182 дугаар Конвенцийн арга зүйн удирдамж, ОУХ-ийн Товчоо, ОУПХ
5. ҮСХ. ОУХБ. Биеэ үнэлэгч болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн судалгаа. 2010. 25 дахь тал
6. ЭМЯ, ЭТҮГ, НҮБХС. Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл ба түүний эрүүл мэндийн үр дагавар. УБ., 2004
7. ЮНЕСКО. Монголын хэвлэл, мэдээллийн салбарын төлөв байдал. УБ., 2007
8. ЮНИСЕФ, ЮНЕСКО “Бүх нийтийн боловсрол дахь хүний эрхэд суурилсан хандлага” Бодлогын баримт бичиг, УБ, Согоонуур хэвлэх үйлдвэр, 2008
9. Д.Эрдэнэчимэг, Ц.Чимэдлхам нар, “Сургуулийн өөрийн үнэлгээ хийх арга зүй” УБ, 2007
10. Бүх нийтийн боловсрол дахь хүний эрхэд суурилсан хандлага. НҮБХС, НҮББСШУСБ. 2007

Гадаад хэл дээрх

1. А. А. Рукашников, М.В Соколова. Факторный личностный опросник Р.Кеттелла. Санкт Петербург. 2003
2. ILO, Time-Bound Programme, Manual for Action Planning, Guide book II, International Labour Organization, 2003
3. ILO, International Labour Standards Department⁸ Guide to international labour
4. Nancy Flowers, Human Rights Educator’s Network, Amnesty International USA
5. Raising one voice⁸ A Training Manual for Advocates on the Rights of Child Domestic Workers⁸ Child Workers in Asia, 2005
6. ICAST, Procedures Manual and Field Test Guide for Investigator&Project Managers

7. Prince William County public schools: 2008-2009 Code of Behavior. Providing A World-Class Education
8. UNICEF (2005) A Campaign in East Asia and the Pacific to Stop Violence against children. Bangkok, Thailand
9. Education component. Community based rehabilitation. WHO. UNESCO. ILO. IDDC.
10. Working Paper Series Education Section Programme Division United Nations Children's Fund New York, NY, USA. p: 4
11. Willms, J. D. (2000). Standards of care: Investments to improve children's educational outcomes in Latin America. Paper presented at the "Year 2000 Conference of Early Childhood Development" sponsored by the World Bank, Washington, D.C., April, 2000.